



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөгжлийн
Байгууллага



ЗӨВЛӨХ БАГИЙН
ТАИЛАН



АГУУЛГА

Агуулга.....2

Товчилсон үг3

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал тайланг боловсруулах үндэслэл 4

1.1 Үндэслэл..... 4

2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үзэл баримтлал.....5

2.1 Үндсэн үзэл баримтлал5

2.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл.....6

2.3 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ тогтолцоо болох нь.....7

2.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг институцчилсэн олон улсын туршлага9

3. Монгол улс дахь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний нөхцөл байдал 13

3.1 Монгол улсын ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний тогтолцоо бүрдсэн байдал.....13

3.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт15

3.3 Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, зохицуулалт21

3.4 Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг үзүүлж буй арга хэлбэр28

3.5 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний оролцогч тал 42

3.6 Хүний нөөцийн чадавх 43

3.7 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам55

4.1 Үндсэн чиглэл.....58

4.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх чадавхжуулах сургалтын хөтөлбөр63

4.3 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны жишиг хөтөлбөр (Боловсролын салбар).....65



ТОВЧИЛСОН ҮГ

АМЗ	Ажил мэргэжлийн зөвлөх
АМУЗХ	Ажил мэргэжлийн үндэсний зөвлөхүүдийн холбоо
АМЧБ	Ажил мэргэжлийн чиг баримжаа
АМЧБО	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЯ	Боловсролын яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗХЭДТ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
МАММЗХ	Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
ММСС	Монголын мянганы сорилтын сан
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУИС	Монгол улсын их сургууль
МҮИС	Монголын үндэсний их сургууль
МХНМХ	Монголын хүний нөөцийн менежментийн холбоо
МЧБ	Мэргэжлийн чиг баримжаа
МЧБО	Мэргэжлийн чиг баримжаа олгох
НБГ	Нийслэлийн боловсролын газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ССҮТ	Сэтгэл судлалын үндэсний төв
ССХ	Сэтгэл судлалын хүрээлэн
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ХБ	Хөдөлмөрийн бирж
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХНМХ	Хүний нөөцийн менежментийн холбоо
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТБ	Хөдөлмөрийн төв бирж
ХХБ	Хөдөлмөрийн хувийн бирж
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭҮСМҮТ	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төв
ХЭҮТ	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв
ХЭС	Хөдөлмөр эрхлэлтийн сан
ХЯ	Хөдөлмөрийн яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

1.

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэслэл

Иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтоо үндэслэлтэй хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2016-2020 онд Ажил, мэргэжлийн үндэсний хөтөлбөрийг батлан мөрдсөн билээ. 2020 онд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусгавар болсноор ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг хүргэх оролцогч талуудад баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах эрэлт, хэрэгцээ байсаар байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулга, сургагч багшид тавих шаардлагыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд тогтоох, Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйл Албан боловсролын хөтөлбөр агуулгын хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгохоор, мөн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар бүлэгт Мэргэжлийн болон техникийн боловсролын харилцаанд оролцогчдын тодорхойлохдоо 19 дүгээр зүйлд түншлэгч аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэгт “иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилтны мэргэшлийн түвшнийг дээшлүүлэх, ур чадвар, чадамж эзэмшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах” тус тус заасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг хүрээг сайжруулах ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөх багтай хамтран “Ажил, мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл” боловсруулахаар ажиллаж байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний тогтолцоо, энэхүү үйлчилгээний хэрэгжилтийн нөхцөл байдал, цаашдын хэрэгцээг тодорхойлж, дүгнэлт зөвлөмж гаргаж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний үндсэн чиглэлийг боловсруулахад ашиглах зорилготой.

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ эрх зүйн бичгийн судалгаа хийх
- Ажил мэргэжлийн баримжаа олгох зорилтот бүлгийн статистик үзүүлэлт, гүйцэтгэлийн үзүүлэлтийг харьцуулан дүгнэх
- Ажил мэргэжлийн зөвлөхийн сургалтын хөтөлбөрүүдтэй танилцах, агуулгад анализ хийх

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын мэдээ тайлан, www.1212.mn вэб сайт болон бусад албан ёсны мэдээллийн эх сурвалж, судалгаа, тайлангийн материалууд, тухайн асуудал хариуцсан удирдах ба гүйцэтгэх албан тушаалтнуудаас тодруулга, мэдээлэл авч энэхүү тайланг боловсруулав.

2.

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.1 Үндсэн үзэл баримтлал

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх нь нийгмийн хөгжлийг дэмжих, хөдөлмөрийн хуваарилалтыг боловсронгуй болгох, үйлчлүүлэгчийг хувь хүний болон эдийн засгийн хувьд үр нөлөөтэй байдлаар тохирох ажилд нь хуваарилах, мэргэжил эзэмшүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ нь XIX, XX зууны зааг дээр үүссэн. Түүхчид үйлдвэржилт хурдацтай хөгжиж, улмаар хүмүүс томоохон хот суурин газрууд руу нүүдэллэснээс үүдэн бий болсон ядуурал, ажилгүйдэл, эмх замбараагүй байдлыг арилгахад чиглэсэн нийгмийн хөгжлийн дэвшилтэт хөдөлгөөн гэж ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөх үйлчилгээг тодорхойлсон байдаг.

“Мэргэжлийн чиг баримжаа олгох” гэсэн нэр томъёог анх Харвардын их сургуулийн профессор Ф.Парсонс хэрэглэсэн бөгөөд 1908 онд Бостон хотод мэргэжил сонгоход туслах Америкийн мэргэжлийн товчоо гэдэг байгууллагыг үүсгэн байгуулжээ. Энэ нь төрийн хөдөлмөр эрхлэлтийн товчоог байгуулах үндэс суурь болсон бөгөөд АНУ-д ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх анхны институт болсон юм. Энэхүү байгууллага нь ажил хайгч залуусыг ажилд амжилттай зуучлах зорилтыг дэвшүүлэн ажиллаж эхэлсэн байдаг.

Ф.Парсонс бие хүн ирээдүйн мэргэжлээ сонгох "гурван хүчин зүйлийн загвар" нэртэй онолын баримтлалыг боловсруулсан.

- **Нэгдэх хүчин зүйл:** Мэргэжлээ сонгох гэж байгаа бие хүн өөрийгөө таньж мэдэх, өөрийн чадавх, ур чадвар, сонирхол, хийх дуртай ажил үйл, өөрийн боломж, хязгаар, тэдгээрийнхээ шалтгааныг мэдсэн байх;
- **Хоёрдох хүчин зүйл:** Тодорхой мэргэжлээс ажилчин хүнд тавигддаг нөхцөл шаардлага болон мэргэжлийн үйл ажиллагааны агуулга чиглэл, боломж, цаашдын төлөвийг судалж мэдэх;
- **Гуравдах хүчин зүйл:** Өмнөх хоёр хүчин зүйлийг ухаалгаар харгалзуулан үзэх, өөрийн шинж чанарыг мэргэжлийн шаардлагатай харьцуулж, шүүн тунгаах.

Мөн ажил мэргэжлийн зөвлөгөөг бий болгох, хөгжлийг нь дэмжих эхний үе шатанд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор сэтгэл зүйн тестийг ашиглаж эхэлсэн явдал байсан гэж судлаачид үздэг. Сэтгэл зүйн тест нь ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчийн өөрийн үнэлгээний эхний шатны чухал бүрэлдэхүүн хэсэг болсон. Сэтгэл судлалын шинжлэх ухаанд суурилсан бодитой аргачлалын ач тусаар ажил мэргэжлийн зөвлөгөө нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх бас нэгэн хүчин зүйл байсан.

Ажил мэргэжлийн зөвлөгөөг бий болгох өөр нэг чухал хүчин зүйл нь “Дэвшилтэт нийгмийн шинэчлэл” нэрэн дор хийгдсэн хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийг устгах тэмцэлд Парсонс нэр хүнтэй удирдагч байсан. Цаашлаад ажил мэргэжлийн баримжаа олгохыг дэмжсэн хуулиуд нийгмийн дэмжлэгийг авч эхэлсэн байдаг.

АНУ-ийн ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөх үйлчилгээний хөгжлийн үе шатыг тоймловол:

1. Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ институтчилэгдсэн үе (1890–1919)
2. Ажил мэргэжлийн зөвлөгөө боловсролын салбарт нэвтэрсэн үе (1920–1939)
3. Коллеж, их дээд сургуульд ажил мэргэжлийн зөвлөхүүдийг бэлтгэж эхэлсэн үе (1940–1959)
4. Байгууллага дахь ажил мэргэжлийн зөвлөгөө хөгжсөн үе (1960–1979)
5. Ажил мэргэжлийн зөвлөхийн статус бие даасан хэлбэрт шилжсэн үе (1980–1989)
6. Ажил мэргэжлийн зөвлөгөөний шинэ эрин үе (1990 оноос одоог хүртэл)

Дээрх түүхэн тоймоос харахад ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээний хөгжил нь тухайн нийгмийн хөгжлийн онцлог, хэрэгцээтэй салшгүй холбоотой байгааг харж болохоор байна.

Аж үйлдвэрийн эрин үед “карьер” -ийн тухай нийтлэг хандлага нь үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагад ажиллаж албан тушаал шатлан ахих эсвэл мэргэжлээрээ зэргээ ахиулах явдал байсан. Энэ хандлагын дагуу хүмүүс бид карьерыг “сонгодог” тухай ярьж, дараа нь сонгосон мэргэжлээрээ суралцаж, ажиллаж түүнийгээ эмх цэгцтэй удирдахыг “Карьер” гэж ойлгодог байв. Энэ ойлголт, хандлагаар дүгнэвэл хүмүүсийн зарим нь карьертай байсан, ихэнх нь зөвхөн ажилтай байсан, заримд нь аль нь ч байгаагүй.

Харин 2000 оноос хойш карьерын тухай энэхүү үзэл баримтлал, ойлголт өөрчлөгдөж эхэлсэн байна. Мэдлэгийн хүрээ тэлж инновац-технологийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх явцад шинэ мэргэжил ажлын байрууд олноор бий болж байна. Технологи, даяаршлаас үүдэлтэй өөрчлөлтийн хурд байгууллагуудад ч мөн нөлөөлж өөрчлөлт шинэчлэлийг бий болгосон. Ажлын нөхцөл илүү уян хатан байдалд шилжсэн. Бид үүнийг олон төрлийн ажил үүргүүд цагийн ажил, кластраар ажиллах системд шилжсэнээр харж болно. Мөн Ковид-19 цар тахлаас хойш оффисоос ажилдаг нэлээдгүй ажил, үүргийн агуулга өөрчлөгдсөнийг дурдаж болох юм.

Нийгмийн хувьсал өөрчлөлт, технологийн шинэчлэл, ажил олгогчийн хандлагын өөрчлөлт зэргээс хамаарч ажил, мэргэжил/карьер (career)-ийн тухай ойлголт хандлага ч шинэчлэгдсээр байна. Судлаачид Карьер гэх ойлголтыг “зорилготой ажиллаж, амьдрах буюу чанартай амьдралыг бий болгохын тулд хөдөлмөрлөх, суралцах насан туршийн үйл явц” гэж тодорхойлсон. Карьерыг сонгохоо больсон. Энэ нь бидний амьдралдаа хийдэг цуврал сонголтын үр дүнд бий болдог. Энэ утгаараа карьерын хөгжлийг цөөн хэдэн хүнээр хязгаарлах ёсгүй бөгөөд бүгдэд хүртээмжтэй байх тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх нэн шаардлагатай юм.

Энэ бүхнээс дүгнэхэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ нь насан туршийн, системтэй үйл ажиллагааны үр дүн буюу “аль ч насны хувь хүмүүст тэдгээрийн амьдралынх нь аль ч үед боловсрол, сургалт, ажил эрхлэлтийнхээ талаар сонголт хийж ажил мэргэжлээ баримжаалахад нь туслах үйлчилгээ ба үйл ажиллагаа” болон хөгжжээ.

Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний түүхийг тоймлож болох юм.

1. Аж үйлдвэржилтийн эхэн үе
2. Мэргэжилтэй ажилтны тогтолцоо бүрдсэн үе
3. Нийгмийн шилжилтийн үе
4. Ажил мэргэжлийн баримжаа олгох тогтолцоо дахин бүрдэж эхэлсэн үе (2009–одоог хүртэл)

2.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл

Сүүлийн хорин жилийн хугацаанд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээнд суурилсан хөдөлмөр зуучлалын үр дүн, үр нөлөөг сайжруулах зорилго бүхий төрийн бодлогыг Европ тивд хэрэгжүүлж байна. Үүний шалтгаан нь юуны түрүүнд эдийн засгийн Евро бүсийг бэхжүүлэхийн тулд хөдөлмөрийн насны иргэд амьдралынх нь туршид

зөвлөгөө өгөх байдлаар мэргэжлийн чадамжийг насан туршид нь хөгжүүлэхэд оршиж байна.¹

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ нь бодлого боловсруулагчдын хувьд гурван үндсэн зорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг болдог “арга хэрэгсэл” гэж судлаач A.C.Watts (2005) үзсэн.

Нэг. Боловсролын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлтэй харилцах харилцааг удирдах зорилтыг хангахад тэргүүлэх байр суурьтай үйлчилгээ юм. Үүнийг Монгол улс боловсролын салбарт хэрэгжиж буй тус үйлчилгээг “Бүх төрлийн, бүх түвшний сургалтын үр дүн хөдөлмөрийн зах зээлтэй холбогддог”² гэсэн байдлаар томъёолж ажил мэргэжлийн баримжаа олгох хичээлийн сургуулийн удирдлагад зориулсан гарын авлагад тусгаж өгчээ.

Хувь хүмүүс сурах зүйлээ өөрийн сонирхол, чадавх, хүсэл тэмүүлэлтэй уялдуулан, мэдээлэлтэй, нухацтай шийдвэр гаргавал боловсрол сургууль завсардалт буурах, сурлагын амжилтыг дээшлүүлэх замаар боловсрол, сургалтын системд оруулсан асар их мөнгө өндөр өгөөжтэй байж, сургалтын үйл ажиллагаа үр дүнд хүрнэ.

Хоёр. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн уялдаа холбоог сайжруулах, өөрчлөлтийг удирдах нь хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилтыг хангах явдал юм. Хүмүүс өөрсдийн нөөц боломж, сонирхол чадвартаа нийцэх ажил олох чадвар нь тэднийг урам зоригтой, бүтээмжтэй байдлыг нэмэгдүүлдэг. Энэ нь хөдөлмөрийн эдийн засгийн хувьд оновчтой ур чадвар юм.

Гурав. Нийгмийн оролцоог дэмжих, тэгш байдлыг хангах зорилтуудыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлдэг. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ нь эмзэг бүлгийн хүмүүсийн хөдөлмөр эрхлэх хүсэл тэмүүллийг дээшлүүлж, тэдэнд хаалттай байсан боломжуудыг олж авахад нь дэмжлэг үзүүлдэг.


Эдгээр гурван зорилт нь улс орон бүрийн хувьд харилцан адилгүй байдлаар тодорхойлогддог. Гэвч дээрх зорилтууд нь нийтлэг байдлаар хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн үзэл баримтлалтай уялдан насан туршийн боловсролтой холбоотой байдлаар бодлогын бичиг баримтад тусгагдаж байна.

2.3 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ тогтолцоо болох нь

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ нь хөгжингүй улс орнуудад зуу гаруй жилийн өмнө үүсэж, хөгжиж ирсэн түүхтэй. Улс орнууд энэхүү харилцааг өөрийн нийгэм, эдийн засаг, технологийн хөгжил, соёл, уламжлалд тохирсон онцлог байдлаар институтчилсэн байна.

¹ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ, Бернд-Йоахим Эртельт, Михаэл Шарпф, М.Баянмөнх, Ч.Эрдэнэчимэг, 2017, хууд. 13

² “Ажил мэргэжлийн чиг баримжаа” ахлах ангийн багш нарын гарын авлага, УБ, 2018



2.4 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг институтчилсэн олон улсын туршлага

Харилцааг институтчилэх үйл явцын агуулга	Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний институтчилэл				
	Казахстан улс	ОХУ	АНУ	Беларус улс	ХБНГУ
Нийгмийн эрэлт	+++	+++	+++	+++	+++
Чиг үүрэг, статусыг тогтоох	Сурагч залуучууд ирээдүйн мэргэжлээ үндэслэлтэй сонгоход шаардлагатай мэдлэг, чадвар, дадал олгох явдлыг бодлогын түвшинд авч үздэг. АМЧБО ажлын статусыг Казахстан улсын боловсролыг 2011-2020 онд хөгжүүлэх хөтөлбөрт тодорхойлсон.	Ерөнхий боловсролын сургуульд МЧБО ажлыг тусгайлан авч үзэж, онцгой ач холбогдол өгдөг. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох албан ёсны тогтолцоо бүрэлдсэн.	Сурагч залуучуудыг ирээдүйн мэргэжил, карьерын хөгжилд бэлтгэх асуудлаар Конгрессын акт гаргаж, статусыг тогтоосон	МЧБО үзэл баримтлалыг баталсан байна. АМЧБО асуудал, сургалт, хөтөлбөрийг үзэл баримтлал, эрхзүйн бусад баримт бичгээр баталгаажуулсан	МЧБО, "мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх", "хөдөлмөр эрхлэлт"-ийн эрэлтийг төрийн бодлогын түвшинд тавьсан, Мэргэжил, мэргэжлийн хөдөлмөр, АМЗ үйлчилгээний эрэлтийг жил, жилээр төлөвлөж, бодлогын түвшинд зохион байгуулж, шийдвэрлэдэг. МЧБО үйлчилгээг бодлогын түвшинд тавьж, статусыг тогтоосон.
Чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага бий болгох	Казахстан улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, бүтцийн байгууллагууд.	- Залуучуудад МЧБО, карьерын хөгжлийн тэргүүлэх төв - ЕБС дээр АМЧБО төв - АМЧБО сургалтын хөтөлбөрүүд - Хотуудын дүүрэг дэх МЧБО, карьерын хөгжлийн төвүүд - Мэргэжил-хөгжил форум, жил бүр - АМЧБО товчоо Соционик эрдэм шинжилгээний институт - Карьер хөгжлийн төв	АНУ-ын Боловсрол, хөдөлмөрийн департментын чиг үүрэгт хамаарах бөгөөд "Сургуулиас-хөдөлмөрийн зах зээлд" хөтөлбөр хэрэгжүүлдэг.	Боловсролын яам, Мэргэжлийн тестийн оношилгооны бус нутгийн төв. Их дээд сургуулиудын дэргэдэх мэргэжлийн чиг баримжаа олгох нэгж,	АМЧБО үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийн холбооны агентлаг хариуцдаг; АМЧБО төрийн албан ёсны сүлжээ тогтсон.
Дүрэм, журам, хэм хэмжээг төлөвшүүлэх	"Компетенци"-д суурилсан сургалтын технологи (сурагчдад	- МЧБО ажлын чиглэл: - МЧБО хичээл,	- Мэргэжил судлах хичээл, - Мэргэжлийн үйл ажиллагааг ажиглах;	МЧБО хичээл;	МЧБО хичээл нь сургалтын хөтөлбөр, стандартад тусгагдсан,

Харилцааг институтчилэх үйл явцын агуулга	Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний институтчилэл				
	Казахстан улс	ОХУ	АНУ	Беларус улс	ХБНГУ
	ирээдүйн мэргэжлээ үндэслэлтэй сонгоход шаардлагатай мэдлэг, чадвар, дадал олгох); Гүнзгийрүүлсэн чиглэл бүхий (профиль) сургалт, Гүнзгийрүүлсэн сургалттай сургуульд шилжиж суралцахын тулд урьдчилсан бэлтгэл сургалт явуулдаг (тухайн сурагчийн мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавхыг илрүүлж төлөвшүүлдэг, суралцах хүсэл тэмүүллийг өдөөж хөгжүүлдэг)	- Мэргэжлийн талаар мэдээлэл өгч мэдлэг олгох; - Бие хүний сонирхол, чадавх, онцлог шинжийг судлах; - Мэргэжлүүд дээр өөрийгөө туршиж сорих, - Мэргэжил сонголтын талаар зөвлөгөө өгөх, - Мэргэжилд тохирох эсэх дүгнэлт гаргах, - Мэргэжилдээ дасан зохицоход нь тусалж сурганы үйлчилгээ үзүүлэх г.м. - Мэргэжил сонголтын сурах бичиг, гарын авлага, - Мэргэжил сонгох алгоритм логик алхам, - Мэргэжлийн стандарт, - Судалгаа, боловсруулалтын ажил.	- Ажлын байран дээр өөрийгөө туршиж үзэх; - Нийгмийн тустай хөдөлмөр болон сайн дурын ажилд оролцуулах; - Төгсөгч бүр өөрийн "портфолио" бүрдүүлдэг, - Карьерын хөгжлийн сургалт (мэргэжлийн боловсрол олгох бүх шатны сургуульд); - Мэргэжлийн боловсролын сургууль бүрд карьерын зөвлөх (career counselor) ажилладаг.	- МЧБО сургалт, хичээлийг 6 дугаар ангиас (12 нас) эхэлдэг, - МЧБО багш мэргэжлийг шинээр бий болгосон - МЧБО мэдээллийн нэгд-мэл цахим санг байгуулсан.	- бусад хичээлийн адил статустай, - Мэдээллийг хүртээмжтэй түгээдэг; - Мэргэжил, мэргэжилтэй ажилтны хэрэгцээг бүх салбар, бүс нутаг, үйлдвэр, мэргэжил нэг бүрээр тодорхойлдог; - Мэргэжлийн тайлбар тодорхойлолт, мэргэжлийн толь бичиг, - Гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөр; Үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөр; - Эмнэлгийн болон сэтгэл судлалын мэргэжилтнүүд зөвлөгөө өгдөг, - Төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг (дүрэм, журам, зохион байгуулалт) бүрдүүлсэн.
Хяналт, санхц	+++	+++	+++	+++	+++
Нийтээр ойлгож эзэмших, хэрэглэж хэвшүүлэх (Internalization)	Боловсролын асуудал эрхэлсэн яам, агентлагууд, төсөл хөтөлбөр, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүд, сурагч залуучууд АМЧБО сургалтын утга учир. ач холбогдлыг нэг утгаар ойлгож, идэвхтэй оролцдог.	Боловсролын салбарын яам, агентлагууд, мэргэжлийн болон ЕБС, удирдлага, багш нар, эцэг эх, асран хамгаалагчид, суралцагч, залуучууд нэгдсэн ойлголттойгоор оролцдог.	Боловсрол, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн департамент, төсөл хөтөлбөрүүд, ажил олгогчид, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургуулийн удирдлага, багш нар, зөвлөгч нар, эцэг эх, асран хамгаалагч, сурагч залуучууд АМЧБО тогтолцооны ач	Боловсролын асуудал эрхэлсэн яам, агентлагууд, мэргэжлийн тестийн оношилгооны бус нутгийн төв, их, дээд сургуулиудын дэрэгдэх МЧБО нэгж, төсөл хөтөлбөр, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургуулийн удирдлага, багш нар, эцэг эх, асран хамгаалагчид, сурагч залуучууд АМЧБО	АМЧБО тогтолцооны бүх байгууллага, ажилтнууд, оролцогчид, үйлчилгээг хүртэгч субъектуудад нэгдсэн ойлголт, үнэлэмж тогтсон. Мэргэжлийн болон ерөнхий боловсролын байгууллага, удирдлага, багш, эцэг эх, асран хамгаалагч, сурагч оюутнууд АМЧБО



Харилцааг институтчилэх үйл явцын агуулга	Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний институтчилэл				
	Казахстан улс	ОХУ	АНУ	Беларус улс	ХБНГУ
			холбогдлыг ойлгодог, идэвхтэй оролцдог.	бодлого, үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголттойгоор оролцдог.	үйлчилгээний учир холбогдлыг ойлгосон, идэвхтэй оролцдог.

Улс орнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг институтчилсэн туршлагыг шинжилж үзвэл дараах нийтлэг хандлага ажиглагдаж байна.

АМЧБО бодлого, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалт, хамрах хүрээ, зохицуулалтын механизм нь нийгмийн эрэлтийг иш үндэс болгож, түүнд тулгуурласан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний үүрэг нийгмийн ач холбогдол, статусыг төрийн бодлогын баримт бичиг, эрх зүйн актуудад нэг утгаар хуульчлан тодорхойлсон байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүргийг боловсрол, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллагад оноосон байна. Боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн дунд түвшний байгууллагууд Ерөнхий болон мэргэжлийн боловсролын сургуулиуд АМЧБО үйлчилгээний судалгаа, боловсруулалт, арга зүйн асуудал эрхэлсэн хүрээлэн, төв г.м.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, насанд хүрэгчдэд зориулсан хөтөлбөрүүд бий болгосон (Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр. Карьерын хөгжлийн хөтөлбөр. Хөдөлмөр зүй г.м); Сурах бичиг, гарын авлага, арга зүйн удирдамж, Мэргэжлийн стандарт, тодорхойлолт, толь бичиг, АМЧБО үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сүлжээ "Ажил мэргэжлийн зөвлөх". "Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх мэргэжилтэн" зэрэг мэргэжил, орон тоог бий болгосон, Зөвлөх мэргэжилтний үндэсний чадавхыг бүрдүүлсэн. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хэрэгжүүлэхэд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажил олгогчдын үүрэг оролцоог тодорхойлсон г.м.

АМЧБО үйлчилгээний ач холбогдлыг бүх оролцогчид (сурагчид, насанд хүрэгчид, өрх айл (гэр бүл), сэтгэл судлал сурганы судлаачид, багш нар, сэтгэл судлалын төв, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох алба, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, байгууллага, үйлдвэр, компани, төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага г.м) нэгэн утгаар ойлгож, үүргээ биелүүлж, хамтран ажилладаг байна: Институтийн оролцогчид байнга, нягт хамтран ажилладаг. (институтчилэгдээгүй харилцаа нь байнгын биш, тохиолдлын, өнгөц чанартай) Үйлчлүүлэгчдэд мэдлэг, мэдээлэл дамжуулах үүрэгтэйгээр тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа, хүчин чармайлт нь эн тэргүүнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд төвлөрсөн (мэргэжих үйл явц) Бүх оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага, хяналтын механизм яв цав тодорхойлогдсон байна.

3.

МОНГОЛ УЛС ДАХЬ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1 Монгол улсын ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний тогтолцоо бүрдсэн байдал

Монгол улсад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ нь боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төр, бизнес, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжиж байна. Тус үйлчилгээг хүргэх оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, хамтын ажиллагааны хэлбэрийг төрийн бодлого, хууль, эрх зүй, төсөл, хөтөлбөрийн зэрэг баримт бичгүүдэд дараах байдлаар тусгаж өгсөн байдаг.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндэслэл нь :

- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Боловсролын ерөнхий тухай хууль (2023)

Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, **насан туршдаа суралцаж, ажиллах**, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (2023)

Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023)

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, мэргэжил, ажлын байрны мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, ажил мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх


Ерөнхий боловсролын сургуулийн захиргаатай хамтарч ахлах ангийн сурагчдад АМЧБО үйлчилгээ зохион байгуулах

АМЧБО оновчтой тогтолцоо нь иргэдэд сонирхол, чадавхаа нээж харуулах үндсэн дээр ажил мэргэжлээ зөв сонгож сурч эзэмших, тасралтгүй өсөж хөгжихөд нь сэтгэлзүй сурганы дэмжлэг үзүүлэх зорилготой.

Харилцааг институтчилэх үйл явцын агуулга	Институтчилсэн арга хэлбэр
Нийгмийн эрэлт	Монгол улсын хэмжээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний хэрэглэгчийн тоймыг харуулбал дараах дүр зураг харагдаж байна. ❖ 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн 8-12 ангийн суралцагчдын тоо: 254,682 - 8 анги – 61,403 - 9 анги – 64,408 - 10 анги – 50,247 - 11 анги – 43,202 - 12 анги – 35,422 ❖ 2021-2022 оны хичээлийн жилд МБСБ-ын төгсөгчдийн тоо: 22,251 - Мэргэжлийн боловсрол төгсөгч – 18,318 - Техникийн боловсрол төгсөгч – 1,729 - Мэргэжлийн сургалт төгсөгч – 2,204 ❖ 2022-2023 оны хичээлийн жилд дээд боловсролын төгсөгчдийн тоо: 23,314 - Дипломын дээд – 1,102 - Бакалавр – 17,260 ❖ 2024 оны 05 сарын байдлаар Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ авсан иргэдийн тоон мэдээлэл - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ авсан иргэн – 3382 - Бүлгийн сургалт зөвлөгөө авсан иргэн – 7292
Чиг үүрэг, статусыг тогтоох	- Боловсролын ерөнхий хууль - Сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын тухай хууль - Мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол сургалтын тухай хууль - Дээд боловсролын тухай хууль - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
Чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага бий болгох	❖ Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар - ХХҮГ/ХХҮХэлтэс (21 аймаг 9 дүүрэг) - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт ❖ Боловсролын яам - Боловсролын ерөнхий газар - Нийслэлийн боловсролын газар - Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн - Аймаг, дүүргийн боловсролын хэлтэс - Насан туршийн боловсролын төв - Ерөнхий боловсролын сургалтын байгууллага - МБСургалтын байгууллага - Дээд боловсролын сургалтын байгууллага
Дүрэм журам, хэм хэмжээг төлөвшүүлэх	- Хөдөлмөрийн сайд, БСШУЯ сайдын A165/A266 хамтарсан тушаал – 2016.06.24 Ажил мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл (2016–2020) - ХХҮЕГ-ын даргын A/249 тоот тушаал: 2017.09.25 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, сургалтын тайлангийн маягт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулга - ХХҮЕГ-ын даргын A/179 тоот тушаал: 2017.09.25 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж - ХХҮЕГ-ын даргын A/263 тоот тушаал: 2017.10.06 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох зөвлөмж - БСШУ-ны сайдын A/200 тоот тушаал: 2020.12.23 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэл
Хяналт	- Үндэсний Аудитын газар, Гүйцэтгэлийн нийцлийн аудитын газар - ГБХНХЯ, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар - ХХҮЕГ, Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар - Аймаг/дүүргийн хэлтэс/газрын Захиргаа, хяналтын хэлтэс - БЯ, Хяналт шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтэс - БЕГ, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар - НБГ, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

3.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт

Мэргэжлийн хөгжил(career development) нь хөдөлмөрийн амьдралын туршид үргэлжилдэг, үе шаттай үйл явц юм. Ажил мэргэжилд чиглэсэн сонирхол үүсэхээс эхлээд мэргэжлийн амьдралыг бүхэлд нь хамарч буй энэ үйл явц нь шулуун дардан биш, тэнцвэртэй биш, магадлалын шинжийг агуулдаг учраас үе шат бүртээ ажил мэргэжилтэй холбоотой тулгамдаж буй асуудлаараа зөвлөгөө, чиглүүлэг авах эрэлт, хэрэгцээг нийгэмд бий болгодог. Эрдэмтэн судлаачид бие хүний мэргэжлийн хөгжлийн үйл явцыг түгээмэл зүй тогтлоор нь тодорхой ангиллуудад хувааж үзсэн байдаг.



1. Өсөлтийн үе шат: Мэргэжил сонголтод бэлтгэх үе(0-14 нас)
2. Эрэл хайгуулын үе шат: Янз бүрийн ажил үйл өөрийгөө сорих, хүч чадлаа үнэлэх туршилтын үе (15-24 нас)
3. Төлөвших үе шат: Мэргэжлийн үйл ажиллагааны тодорхой төрлийг сонгон авч, эзэмших, бататгах үе (25-44 нас)
4. Мэргэжлийн үйл ажиллагаагаа хадгалах үе шат: Сонгосон мэргэжлийн үйл ажиллагаандаа зохистой үр дүнд хүрдэг үе (45-64 нас)
5. Бууралтын үе шат: Бүтээмж буурч эхлэх үе (65 дээш нас)

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний агуулга, зорилтот бүлгийг тодорхойлохдоо хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгарч буй асуудал, мөн түгээмэл зүй тогтол, насны хөгжил, боловсролын тогтолцоо зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.


Манай улсын хувьд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн болон боловсролын салбарт дараах зорилтот бүлэгт үзүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн салбар	Боловсролын салбар
• Хүүхэд залуучууд ○ ЕБС-ийн ахлах ангийн суралцагч (8-12 дугаар анги) ○ Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч ○ Их дээд сургууль, коллежийн оюутан ○ Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн • Насанд хүрэгчид ○ Ажил хайгч иргэн ○ Хугацаат цэргийн албан хаагч ○ Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирж буй иргэн • Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн ○ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ○ Эмзэг эрсдэлтэй бүлгийн иргэн	• Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ○ 8-9-р ангийн суралцагчид ○ 10-12 ангийн суралцагчид


- Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн³

Боловсролын салбарын статистик ажил мэргэжлийн чиг баримжаа үйлчилгээний тухайн салбарын зорилтот бүлгийн эрэлтийг тоон үзүүлэлтээр харах боломж бүрдүүлж байна.


Ерөнхий боловсролын сургуулийн ахлах суралцагчид (2018-2023 он)



Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчид (2018-2022 он)



Дээд боловсролын байгууллагын төгсөгчид (2018-2023 он)




³ ХХҮЕГ-ын даргын А/249 тоот тушаал - 2017.09.25

Хөдөлмөр эрхлэлтийн салбарын статистик нь бидэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг нийлүүлэлт талаас нь харьцуулж харах боломж бүрдүүлж байна

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тоон үзүүлэлт 2019-2023 он⁴

Үйлчилгээ	Он	Ганцаарчилсан зөвлөгөө	Бүлгийн зөвлөгөө	Нийт	Өсөлт, бууралт хувиар/өмнөх онтой харьцуулахад %/
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ	2019	43,002	75,582	118,584	21,1 ↑
	2020	31,743	19,824	51,567	56,5 ↓
	2021	37,016	35,593	72,609	28,9 ↑
	2022	30,253	62,536	92,789	21,7 ↑
	2023	21,615	55,317	76,932	17↓

Ганцаарчилсан үйлчилгээ авсан иргэн (хүйсээр)




Ганцаарчилсан үйлчилгээ авсан иргэн, боловсролын байдал


	2019	2020	2021	2022	2023
Боловсролгүй	982	594	806	669	229
Бага	775	748	586	848	999
Суурь	2,827	2,113	3,235	2,318	2,584
Бүрэн дунд	27,032	19,922	23,081	19,489	14,086
Техникийн болон мэргэжлийн анхан шат	1,952	1,412	1,761	1,421	1,197
Тусгай мэргэжлийн дунд	1,763	1,296	1,469	1,114	869
Дипломын болон бакалаврын дээд	7,385	5,447	5,905	4,208	1,501
Магистр, доктор	279	211	173	186	150
Дүн	42,995	31,743	37,016	30,253	21,615
Өсөлт, бууралт (өмнөх жилээс)		-26.2%	16.6%	-18.3%	-28.6%

⁴ www.hudulmur-halamj.gov.mn


Ганцаарчилсан үйлчилгээ авсан иргэн (Насны бүлгээр)




Ганцаарчилсан үйлчилгээ үзүүлсэн мөнгөн дүн, сая төгрөг (Насны бүлэг)




Ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл авсан иргэд (Үйлчилгээний төрөл байдлаар)




Ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл авсан иргэд, үйлчилгээний төрөл байдлаар




Бүлгийн сургалт



Бүлгийн сургалтанд хамрагдсан зорилтот бүлгийн иргэд



Бүлгийн сургалт – сургалтын төрөл



Дээрх өгөгдсөн тооноос ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний эрэлт болон нийлүүлэлтийн харьцааг дүгнэж үзвэл дараах дүн гарч байна.

Он	АМЧБО үйлчилгээ авсан иргэдийн тоо	Үүнээс		Тухайн жил суралцсан нийт суралцагчдын тоо		АМЧБО үйлчилгээний харьцуулсан дүн	
		ЕБС 9-12 ангийн суралцагчид	МСҮТ, их, дээд сургуулийн төгсөгчид	ЕБС 9-12 ангийн суралцагчид	МСҮТ, их, дээд сургуулийн төгсөгчид	ЕБС 9-12 ангийн суралцагчид	МСҮТ, их, дээд сургуулийн төгсөгчид
2019	118,584	48,788	10,322	169,013	50,370	28.9%	20.5%
2020	51,567	13,813	2,285	185,581	46,932	7.4%	4.9%
2021	72,609	24,585	3,379	216,316	50,895	11.4%	6.6%
2022	92,789	50,089	3,018	238,327	55,176	21.0%	5.5%
2023	76,932	3,228	41,036	254,682	43,834	1.3%	93.6%
Нийт	412,481	140,503	60,040	1,063,919	247,207	13.2%	24.3%
		200,543		1,311,126		15.3%	

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд үзүүлж буй ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын 13,2 хувь, МСҮТ, их дээд сургуулийн төгсөгчдийн 24,3 хувийг хамруулж байна. Энэ нь дунджаар тус үйлчилгээний 48 хувьтай тэнцэх тоон үзүүлэлт юм.

3.3 Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, зохицуулалт

Өнөөгийн байдлаар Монгол улсад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг иргэдэд хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүй, бодлогын дараах баримт бичгүүд мөрдөгдөж байна. Үүнд: Монгол улсын Үндсэн хууль, “Алсын хараа–2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын боловсролын ерөнхий хууль (2023), Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (2023), Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023), Дээд боловсролын тухай хууль (2023), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011) зэрэг юм.

Энэхүү хууль, эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний талаар хэрхэн авч үзсэнийг эрх зүйн орчны зураглалд тусгасан болно

Хүснэгт 1. Ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөх үйлчилгээний эрх зүйн орчны зураглал

№	Баримт бичиг Үйлчилгээ	Бодлого, үзэл баримтлал	Хууль тогтоомж	Тогтоол, тушаал	Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл	Дүрэм журам, стандарт
Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн хүрээнд						
1	Ажил мэргэжлийн талаарх сургалт, мэдээллээр хангах		- Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 14.4.4; 14.4.8; - Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 3.2; 9.1; 20.5; 20.10; - Дээд боловсролын тухай хууль (2023)-ийн 20.5.1-20.5.3;	- БСШУ-ын Сайдын А/620 тоот тушаал (2015) - Монгол улсын Засгийн газрын 71-р тогтоол (2014) - БШУ-ын Сайдын А/316 тоот тушаал (2013) - Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016) - ХХҮЕГ-ын даргын А/249 тоот тушаал (2017) - ХХҮЕГ-ын даргын А/179 тоот тушаал (2017) - ХЭҮЗ-ийн 2023.02.03-ны тогтоол	- АМЧБ-г хөгжүүлэх чиглэл 2016-2020 - ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний өдрийн хурлын тогтоол. Үүнд: 1 дүгээр хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа(хөтөлбөр) 3 дугаар хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа(хөтөлбөр)-ны хүрэх үр дүн	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага (MNS 6620:2016)-ын 10.3 (А)
2	Ажил, мэргэжлийн талаарх зөвлөгөө өгөх		- Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 13.2.4; 13.2.17 - Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын	- Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016) - ХХҮЕГ-ын Даргын А/249 тоот тушаал (2017)	- ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний өдрийн хурлын тогтоол. Үүнд: 1 дүгээр хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага

№	Баримт бичиг Үйлчилгээ	Бодлого, үзэл баримтлал	Хууль тогтоомж	Тогтоол, тушаал	Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл	Дүрэм журам, стандарт
			тухай хуулийн 12.1.3; 15.1.3; 15.1.6; 17.3; 17.4	• ХХҮЕГ-ын даргын А/179 тоот тушаал (2017) • ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний тогтоол	онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа(хөтөлбөр) ○ 3 дугаар хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа(хөтөлбөр)-ны хүрэх үр дүн	(MNS 6620:2016)-ын 10.3 (А)
3	Ажил, мэргэжлийн боловсрол олгох	Монгол улсын ТХҮБ (2030)-ын 2.2.1 (зорилт 2), 2.2.3 (зорилт 2) Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014–2024)-ын 3.5	• Дээд боловсролын тухай хууль (2023)-ийн 20.5.1-20.5.3; • Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023)-ийн 4.1; 6.2; 6.3	• ХХҮЕГ-ын даргын А/179 тоот тушаал (2017) • ХХҮЕГ-ын Даргын А/249 тоот тушаал (2017) • ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний тогтоол	• ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний өдрийн хурлын тогтоол. Үүнд: ○ 1 дүгээр хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа(хөтөлбөр) ○ 3 дугаар хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа(хөтөлбөр)-ны хүрэх үр дүн	
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байранд зуучлах, мэргэжлийн ажилдаа дасан зохицоход нь туслах		• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5.1.2; • Боловсролын тухай хууль (2002)-ийн 32.1.2; • Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 33.3.3-33.3.5; • Дээд боловсролын тухай хууль (2023)-ийн 13.1.1-13.1.5; • Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2023)-ийн 5.1.1; 5.1.4; 12.4;	• ХХҮЕГ-ын даргын А/179 тоот тушаал (2017) • ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний тогтоол	• ХЭҮЗ-ийн 2023.02.03-ний өдрийн хурлын тогтоол. Үүнд: ○ 1 дүгээр хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа(хөтөлбөр) ○ 3 дугаар хавсралт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа(хөтөлбөр)-ны хүрэх үр дүн	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага (MNS 6620:2016)-ын 10.3 (Б; В)
Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хүрээнд						
5	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох		• Боловсролын тухай хууль (2002)-ийн 24.1.10; 25.1.3; 25.1.4; 26.1.24; • Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 32.1.3;	• Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016)		

№	Баримт бичиг Үйлчилгээ	Бодлого, үзэл баримтлал	Хууль тогтоомж	Тогтоол, тушаал	Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл	Дүрэм журам, стандарт
			33.3.3-33.3.5; 40.1.2-40.1.4; 42.1.1-42.1.5;			
6	Салбар хоорондын зохицуулалтын механизм (институт)	АМЧБ-г хөгжүүлэх чиглэл (2016– 2020)-ийн 3.1; 3.2.1-3.2.2;	- Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 25.1.4; 26.1.3; 28.1; 28.2.1; 29.1.1; 29.1.2; - Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009)-ийн 13.2; 24.1.1;	Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016)		
7	Оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлсон байдал		- Монгол улсын үндсэн хууль (1992)-ийн 16.4; 16.7; - Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 40.1.1; 40.1.2; 40.2.4; 42.1.2; 42.1.3; - СӨБ болон ерөнхий боловсролын тухай хууль (2023)-ийн 17.3; 17.4; 18.2.1; 18.2.4; 19.2.4; 19.2.6;			
8	Хариуцлага, хяналтын механизмыг хэрэгжүүлэх	АМЧБ-г хөгжүүлэх чиглэл (2016– 2020)-ийн 7.1.1; 7.1.3-7.1.7;		Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016)		
9	Мэргэжлийн чадавхийг хөгжүүлэх		Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 26.1.2; 27.1.2; 27.1.3; 28.2.5	- Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016) - ХХҮЕГ-ын даргын А/263 тоот тушаал (2017)		
10	ХЗЗ-ийн мэдээллийн системийг хөгжүүлэх		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 18.1; 19.1; 19.2			
11	Оролцогч талуудын хамтын		Боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 41.2.1; 41.2.2;			

№	Баримт бичиг Үйлчилгээ	Бодлого, үзэл баримтлал	Хууль тогтоомж	Тогтоол, тушаал	Хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл	Дүрэм журам, стандарт
	ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх		Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22.8.2; 23.1.4; 23.1.7-23.1.9; 24.1.2; 24.1.4; 26.6.3;			
12	Санхүүжилт	АМЧБ-г хөгжүүлэх чиглэл (2016-2020)-ийн 6.1; 6.2;	- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 21.1; 23.1; 23.3; 23.5; - Дээд боловсролын тухай хууль (2023)-ийн 32.2.1; 32.2.2;	- Хөдөлмөрийн сайд, БСШУ-ны сайдын А/165; А/266 тоот хамтарсан тушаал (2016) - ХНХ-ын Сайдын А/20 тоот ХЭС-гийн 2018 оны төсвийн хуваарийг батлах тухай тушаал (2018)		

Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчны зураглалд байгаа зарим хууль, эрх зүйн баримт бичгүүдэд туссан зүйл заалтуудыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай ОУХБ-ын 88 дугаар конвенц (2016)-ийн 6; 9-зүйл

6 дугаар зүйл

Тохирах ажил эрж олоход нь ажилчдад нь туслах, мөн шаардлага хангах ажилчдыг олоход нь ажил олгогчдод туслах бөгөөд үндэсний түвшинд боловсруулсан журмын дагуу ялангуяа

(i) ажил хайж буй хүмүүсийг бүртгэх, тэдний мэргэжлийн ур чадвар, туршлага, хүсэл сонирхлын талаар тэмдэглэл хөтлөх, тэдэнд ажил олгохын тулд ярилцлага хийх, шаардлагатай бол тэдний биеийн байдал, мэргэжлийн чадамжийг шалгах, зохих тохиолдолд мэргэжлийн удирдамж чиглэл авах буюу мэргэжлийн сургалт, давтан сургалтад хамрагдахад нь туслах

9 дүгээр зүйл

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнууд нь төрийн албан хаагчид байх бөгөөд тэдний эрх зүйн байдал, ажлын нөхцөл нь засгийн газрын өөрчлөлт болон гаднын зүй бус нөлөөллөөс хараат бус байж, тухайн албаны шаардлагад нийцсэн хэмжээнд тогтвортой ажлын байраар хангагдсан байна. (1)
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтныг ажилд авахдаа үндэсний хууль тогтоомжоор заагдсан төрийн албанд сонгон шалгаруулах аливаа нөхцөл, болзлыг баримтлахын хамт гагцхүү ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн түвшинг харгалзан шалгаруулж ажиллуулна. (2)
- Мэргэжлийн түвшинг тодорхойлох арга замыг эрх бүхий байгууллага тогтооно.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхийн тулд зохих бэлтгэл сургалтад хамрагдсан байна. (3)



“Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд

- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. (2.1)
- Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна. (2.3.3)
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ. (2.3.5)
- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ. (2.6.8)
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн салбар дундын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. (2.6.10)
- Хүн амын бүлэг бүрийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. (2.6.13)

Монгол улсын үндсэн хууль (1992)-ийн 16-р зүйл

- Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй; (16.4)
- Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно; (16.7)

Монгол улсын боловсролын ерөнхий хууль (2023)-ийн 13; 14; 25; 26-р зүйл

- Суралцагчийн төлөвшил, хувийн зан чанарыг судлах, сонирхол, сайн тал, авьяас, чадварыг илрүүлэх, хөгжүүлэн дэмжих; (13.2.4)
- Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ: (14.4)
 - ажил мэргэжлийн чиг баримжаа олгох; (14.4.8)
- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах эрхтэй (40.1)
 - хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах; (40.1.2)
 - хүүхдийн нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг таньж мэдэх, хүүхдээ ойлгон хүндлэх, туслах, хараа хяналтгүй орхихгүй байх; (40.2.4)

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль (2023)-ийн 3; 9; 12; 15; 17; 20-р зүйл

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилго (3 дугаар зүйл)
 - Ерөнхий боловсролын зорилго нь суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино (3.2)
- Ерөнхий боловсролын агуулга (9 дугаар зүйл)

- Ерөнхий боловсролын агуулга энэ хуулийн 3.2-т заасан боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ (9.1)
- Суралцагчийн эрх (12 дугаар зүйл)
 - Өөрийн авьяас чадвараа хөгжүүлэх, сурлагын амжилтаа ахиулахад чиглэсэн дэмжлэг авах; (12.1.3)
- Багшийн ажил үүрэг (15 дугаар зүйл)
 - Суралцагчийн мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх; 15.1.3
 - Хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах. 15.1.6
- Удирдах болон бусад ажилтны үүрэг (17 дугаар зүйл)
 - Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих, АМЧБО, эрсдэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг суралцагч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үзүүлнэ (17.3)
- Ерөнхий боловсролын сургууль (20 дугаар зүйл)
 - Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна (20.10)

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023)-ийн 4, 5, 6-р зүйл

- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго (4 дүгээр зүйл)
 - Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино. (4.1)
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын агуулга, хөтөлбөр (6 дугаар зүйл)
 - Мэргэжлийн боловсролын агуулгыг суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах чадамж, хувиараа хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлж, мэргэжил олгох чиглэлээр тогтооно. (6.2)
 - Техникийн боловсролын агуулгыг суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, техник, технологийн үйл ажиллагааг удирдах, гүйцэтгэх чадамж, хувиараа хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлж, мэргэжил олгох чиглэлээр тогтооно. (6.3)

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим (5 дугаар зүйл)

- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаанд (5.1)
 - Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална: хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжлийг дэмжсэн байх. (5.1.4)

Дээд боловсролын тухай хууль (2023)-ийн 2, 20-р зүйл

- Дээд боловсролын зорилго 2 дугаар зүйл.
 - Дээд боловсролын зорилго нь нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино. 2.1
- Сургалтын хөтөлбөр агуулга 20 дугаар зүйл
- Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна доор дурдсан агуулгыг тусгана: 20.5
 - мэргэших хэсэгт тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тухайн салбар, чиглэлийн шинжлэх ухаан, арга технологи. 20.5.3

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)-ийн 2, 8, 9, 10, 11, 12, 23, 29-р зүйл

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ (2 дугаар бүлэг)
 - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ (8 дугаар зүйл)
 - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна. (8.1)
 - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна. (8.2)
 - Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. (8.3)

3.4 Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг үзүүлж буй арга хэлбэр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг зохион байгуулах ажлын хүрээнд дараах журмууд хэрэгжиж байна. Үүнд:

- ХХҮЕГ-ын даргын **A/249** тоот тушаал – 2017.09.25
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, сургалтын тайлангийн маягт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулга
- ХХҮЕГ-ын даргын **A/179** тоот тушаал – 2017.09.25
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж
- ХХҮЕГ-ын даргын **A/263** тоот тушаал – 2017.10.06
Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох зөвлөмж
- Хөдөлмөрийн сайд, БСШУЯ сайдын **A165/A266** хамтарсан тушаал – 2016.06.24
Ажил мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл (2016–2020)

ХХҮЕГ-ын даргын А/249 тоот тушаал - 2017.09.25

- Гэрээний загвар - Сургалтын тайлангийн маягт - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулга			
Тайлангийн маягт			
Тоон үзүүлэлт Зөвлөгөө, мэдээлэл/ Бүлгийн сургалт		Сургалтын тайлан	Тайланд хавсаргах нотлох баримтууд
1. ЕБС-ийн ахлах ангийн сурагчид /VIII-XII/ 2. Мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагч 3. Их, дээд сургууль, коллежийн оюутан 4. Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн 5. Ажил хайгч иргэн 6. Хугацаат цэргийн алба хаагч 7. Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирсэн иргэн 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 9. Эмзэг, эрсдэлтэй бүлгийн иргэн 10. Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн *Зорилтот бүлэг		- Сургалтын төлөвлөгөөт хугацаа - Сургалтын зорилго хангасан эсэх - Сургалтын хөтөлбөр агуулгад нийцсэн эсэх - Нийгмийн төлөөх үр дүн/эерэг өөрчлөлт/ - Хамтын ажиллагааны явцад гарсан алдаа дутагдал - Туршлага сургамж	- Оролцогчдын бүртгэлийн хуудас - Оролцогчдын анкет, иргэний үнэмлэхийн хуулбар - Сургалтын хөтөлбөр, модуль - Хичээлийн файлууд - Сургалтад ашиглагдсан тест, сорил, дүрс зураг, кейс г/м - Сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн судалгаа, хэлсэн дүгнэлт - Сургалтын үйл явдлыг сургалт тус бүрээр багцалж ангилсан альбом/Жишээ нь Сургалт №1...№2.../
Сургалтын хөтөлбөр, агуулга /Хүүхэд залуучууд(1-3), насанд хүрэгчид(4-7), эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн(8-10)/			
№	Зорилтот бүлгийн ангилал	Модулийн нэр/цаг	Агуулга
1	ЕБС-ийн ахлах ангийн суралцагч /8-12 дугаар анги/ Зорилго: Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын талаарх ойлголтыг төлөвшүүлэх, мэргэжил сонголтын арга аргачлалыг эзэмшүүлэх	Модуль-1 Мэргэжлээ зөв сонгож ирээдүйнхээ эзэн болох нь – 2 ак.цаг Модуль-2 Надад ямар мэргэжил тохирох вэ?– 4 ак.цаг Модуль-3 Сургуулиа сонгох нь – 2 цаг	Би хэн бэ? Зорилго, авьяас, сонирхол, хувийн зан төлөвийг хэрхэн тодорхойлох г.м Ажил мэргэжил гэж юу вэ?, ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт, мэргэжилд тохирох зан чанар, ур чадвар г.м Миний сонгох мэргэжил, сургууль, сурах хугацааны зардлаа хэрхэн тооцох, мэргэжил сонголтын төлөвлөгөө, сургууль сонголтын төлөвлөгөө боловсруулах нь г.м
2	Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч Зорилго: Сургуулиа төгсөхөөсөө өмнө ажлын байранд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, ажиллах чиг баримжаатай болгох, өөрийгөө болон байгууллагаа ойлгох чадвар эзэмших	Модуль-1 Ирээдүйгээ төлөвлөж өөрийгөө бэлтгэх нь – 4 ак.цаг Модуль-2 Ажилдаа дасан зохицож өөрийгөө хөгжүүлэх нь – 4 ак.цаг	Та хэн бэ? Зан төлөв, муу зуршлаа олж илрүүлэх, суралцах явцдаа өөрийгөө хэрхэн хөгжүүлэх, төлөвшүүлэх, шийдвэр гаргах, амжилттай суралцаж мэргэжлээ эзэмших төлөвлөгөө боловсруулах Ажлын байраа хэрхэн судлах, хайх, CV, өргөдөл, анкет бөглөх, хөдөлмөрийн гэрээ хийх, ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх, ажлын байранд дасан зохицох, ажлаас халагддаг шалтгаан, хариуцлага г.м
3	Их дээд сургууль, коллежийн оюутан Зорилго: Төгсөхөөсөө өмнө ажлын байранд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, ажиллах	Модуль-1 Ажил хөдөлмөрт өөрийгөө бэлтгэх нь – 2 ак.цаг	Ажил хөдөлмөр гэж юу вэ? Ажил, хөдөлмөр хэзээ эхэлдэг, сонголт хэрхэн хийгддэг, шийдвэр хэрхэн гардаг, өөрийгөө таних, цэгцлэх, ажил хаанаас хайх, ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх, баримт бичиг хэрхэн бүрдүүлэх, ярилцлага хэрхэн явагддаг,

	чиг баримжаатай болгох, өөрийгөө болон байгууллагаа ойлгох чадвар эзэмшсэн байх	Модуль-2 Ажлын ертөнц рүү алхан орох үе – 2 ак.цаг Модуль-3 Ажилдаа эзэн болох нь – 2 ак.цаг	суралцах явцдаа өөрийгөө хэрхэн хөгжүүлэх, амжилттай суралцаж мэргэжлээ эзэмших төлөвлөгөө боловсруулах г.м Эрүүл зөв амьдрах ур чадвар, ажлын байраа хэрхэн судлах, хайх, мэдээллийг ханаас авах, ажилд орох, CV, өргөдөл, анкет бөглөх, хөдөлмөрийн гэрээ хийх, ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх, ажлын байранд дасан зохицох г.м Ажилд орсон эхний 3 сард та юу хийх ёстой вэ?, шинэ ажилтнууд ажилдаа тохирдоггүй буюу ажлаас халагддаг шалтгаан, насанд хүрэгчдийн хариуцлага, хууль дүрэм баримтлах, эрүүл мэндээ хэрхэн хамгаалах г.м
4	Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн Зорилго: Нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, суралцах чиг баримжаатай болгох, өөрийгөө болон бусдыг ойлгох эерэг хандлага, харилцааны ур чадварыг эзэмшсэн байх	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг	Танд тулгараад байгаа асуудал бэрхшээл, стресс, айдсыг хэрхэн даван туулах вэ? (Эрүүл зөв амьдрах ур чадвар, өөрийн үнэ цэнэ, үнэлэмж, өөрт буй боломж, эерэг зөв хандлага г.м) Өөрийгөө бусдад зөв илэрхийлж суралцах, бусад байгууллагатай хэрхэн харилцаа холбоо тогтоох г.м) Хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө мэдээлэл авах, ажил хайгчаар бүртгүүлэх, тохирсон ажлын байранд зуучлуулах, санхүүгийн болон төсөл хөтөлбөр, мэргэжлийн сургалтад хэрхэн хамрагдах г.м
5	Ажил хайгч иргэн Зорилго: Нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, өөрийн сонирхол, ур чадвар, мэргэжилд тохирсон ажлын байрыг хайж олох, тогтвортой ажиллах чиг баримжаатай болгох, эерэг хандлага,	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг	Танд тулгараад байгаа асуудал бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ?, өөрийн үнэ цэнэ, үнэлэмж, өөрт буй боломжийг хэрхэн давуу тал болгох (нарийн цагийн хуваарийн дагуу юмыг цагт нь хийдэг, зориг тэвчээр, тэсвэр, хатуужилтай, сахилга хариуцлагатай, эрүүл чийрэг) г.м Өөрийгөө бусдад зөв илэрхийлж, бусад байгууллагатай хэрхэн харилцаа, холбоо тогтоох, хэрхэн сонгогдож үлдэх г.м/ Хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө мэдээлэл авах, ажил хайгчаар бүртгүүлэх, тохирсон ажлын байранд зуучлуулах, санхүүгийн болон төсөл хөтөлбөр, мэргэжлийн сургалтад хэрхэн хамрагдах
6	Хугацаат цэргийн албан хаагч Зорилго: Цэргийн албанаас халагдахаас нь өмнө ажлын байранд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, өөрийн сонирхол, ур чадвар, мэргэжилд тохирсон ажлын байрыг хайж олох, ажиллах чиг баримжаатай болгох талаар мэдлэг ойлголт өгөх	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг	Танд тулгараад байгаа асуудал бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ?, өөрийн үнэ цэнэ, үнэлэмж, өөрт буй боломжийг хэрхэн давуу тал болгох (нарийн цагийн хуваарийн дагуу юмыг цагт нь хийдэг, зориг тэвчээр, тэсвэр, хатуужилтай, сахилга хариуцлагатай, эрүүл чийрэг) г.м Өөрийгөө бусдад зөв илэрхийлж, бусад байгууллагатай хэрхэн харилцаа, холбоо тогтоох, хэрхэн сонгогдож үлдэх г.м/ Хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө мэдээлэл авах, ажил хайгчаар бүртгүүлэх, тохирсон ажлын байранд зуучлуулах, санхүүгийн болон төсөл хөтөлбөр, мэргэжлийн сургалтад хэрхэн хамрагдах
7	Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирж буй иргэн Зорилго: Хотын соёлд өөрийгөө бэлтгэх сэтгэл зүйн бэлтгэлийг бий болгох, өөрийн сонирхол, ур чадварт тохирсон ажлын байрыг хайж олох, ажиллах	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл	Танд тулгараад байгаа асуудал бэрхшээл, стресс, айдсыг хэрхэн даван туулах вэ?, Эрүүл зөв амьдрах ур чадвар, өөрийн үнэ цэнэ, үнэлэмж, өөрт буй боломж, эерэг зөв хандлага, хотын соёл г.м/ Өөрийгөө бусдад зөв илэрхийлж суралцах, бусад байгууллагатай хэрхэн харилцаа холбоо тогтоох г.м/

	чиг баримжаатай болгох, өөрийгөө болон бусдыг ойлгох эерэг хандлага, харилцааны ур чадвар эзэмшүүлэх	ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг	Хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө мэдээлэл авах, ажил хайгчаар бүртгүүлэх, тохирсон ажлын байранд зуучлуулах, санхүүгийн болон төсөл хөтөлбөр, мэргэжлийн сургалтад хэрхэн хамрагдах гм/
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Зорилго: Нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэх сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, онцлог хэрэгцээнд тохирсон ажлын байранд ажиллах чиг баримжаатай болгох талаар мэдлэг, ойлголтыг олж авсан байх, өөрийгөө бусдыг ойлгох эерэг хандлага, чадварыг эзэмшсэн байх	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг	Танд тулгараад байгаа асуудал бэрхшээл, стресс, айдсыг хэрхэн даван туулах вэ?, Эрүүл зөв амьдрах ур чадвар, өөрийн үнэ цэнэ, үнэлэмж, өөрт буй боломж, эерэг зөв хандлага г.м/ Өөрийгөө бусдад зөв илэрхийлж суралцах, бусад байгууллагатай хэрхэн харилцаа холбоо тогтоох гм/ Хөдөлмөрийн зах зээлийн талаарх зөвлөгөө мэдээлэл авах, ажил хайгчаар бүртгүүлэх, тохирсон ажлын байранд зуучлуулах, санхүүгийн болон төсөл хөтөлбөр, мэргэжлийн сургалтад хэрхэн хамрагдах гм/
9	Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн		
10	Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн Зорилго: Нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэх сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, өөрийн сонирхол, ур чадварт тохирсон ажлын байрыг хайж олох, ажиллах чиг баримжаатай болгох талаар мэдлэг, ойлголтыг олж авсан байх, өөрийгөө болон бусдыг ойлгох эерэг хандлага, чадварыг эзэмшсэн байх.		

ХХҮЕГ -ын даргын А/263 тоот тушаал -2017.10.06

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох арга зүйн зөвлөмж, сургалтын агуулга

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт дараах үндсэн 4 төрлөөс бүрдэнэ/1.6/	
- Ажилд зуучлах үйлчилгээний суурь мэдлэг олгох сургалт – 5 өдөр - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал, олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж, туршлага, чиг хандлага, - Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогын баримт бичгүүд/3.2/- хөтөлбөрийн агуулгад орох сэдэв	Модуль-1 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ Модуль-2 Хөдөлмөр эрхлэлтийг үйлчилгээний хэрэгсэл Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төрлүүд, хөдөлмөрийн зах зээл дээр хэрэгцээтэй байгаа үйлчилгээнүүд Модуль-4 Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ Модуль-5 Зорилтот бүлгийг тодорхойлох нь Модуль-6 Тусгай зорилтот бүлэгт үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ Модуль-7 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд Модуль-8 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний менежмент

	Модуль-9 Ажилд зуучлах үйлчилгээ Модуль-10 Ажил олгогчид үзүүлэх үйлчилгээ Модуль-11 Ажил хайгчдад үзүүлэх үйлчилгээ Модуль-12 Ажилд зуучлах төвийн үйл ажиллагаа *ХНМХ ТББ
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний сургалт – 5 өдөр	Модуль-1 Ажил мэргэжлийн чиг баримжааны тухай ойлголт Модуль-2 Ажил мэргэжлийн чиг баримжааны онол, арга зүй Модуль-3 Ажил мэргэжлийн мэдээллийн багц Модуль-4 Ажил мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ Модуль-5 Ажил мэргэжлийн талаарх зөвлөгөө Модуль-6 Хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөө Модуль-7 Зорилтот бүлгийн иргэдийн онцлогийг харгалзан зөвлөгөө өгөх аргачлал *МММЭХ ТББ
Харилцааны сургалт	*Тушаалд тусгагдсан ч тухайн сургалтын нэр тусгагдаагүй
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургагч багш бэлтгэх сургалт – 5 өдөр	*Тушаалд тусгагдаагүй
Хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох /профайлинг/ сургагч багшийн сургалт – 5 өдөр	*Тушаалд тусгагдаагүй

Хөдөлмөрийн сайд, БСШУЯ сайдын А165/А266 хамтарсан тушаал - 2016.06.24

ЕБС-ийн ахлах ангийн сурагч, хөдөлмөр эрхлэх насны залуучуудад мэргэжил сонгох, суралцах, хөгжих боломж нэмэгдүүлэх зорилгоор “Ажил, мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл”, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.(1)

Зорилго	Зорилт	Хамрах хүрээ
Иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтоо хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэхэд оршино.(3.1)	- Эрх зүйн орчныг боловсронгуй болгох - Ажил, мэргэжлийн чиг баримжааны салбар хоорондын зохицуулалтын механизмыг бий болгох; - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах; - Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, зорилтот бүлгийн иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх; - Эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг уялдуулан зохион байгуулах.(3.2)	- Хүүхэд, залуучууд (1.2.1); - ЕБС-ийн ахлах ангийн суралцагч, - Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч - их, дээд сургууль, коллежийн оюутан; - албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн; - эцэг эх, асран хамгаалагчид; - Насанд хүрэгчид (1.2.2); - Ажил хайгч иргэн - Хугацаат цэргийн албан хаагч - Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэн - Гадаадад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэн - Тэтгэврийн насны иргэн - Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн (1.2.3) - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн - Эмзэг эрсдэлтэй бүлгийн иргэн - Хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэн

Ерөнхий удирдлага, зохицуулалт, хяналтыг хөдөлмөр болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Тайлагнал:

- Аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэс нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээний мэдээг улирлаар гаргаж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төвд хүргүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн дэд төв нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг улирлаар гаргаж, дараа улирлын 15-ны өдрийн дотор хөдөлмөр болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ.
- Тухайн жилд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтэд жил бүр үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, тайланг Засгийн газарт танилцуулна.
- Хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Үйл ажиллагаа

• Эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд (4.2)	• Ажил, мэргэжлийн чиг баримжааны салбар хоорондын зохицуулалтын механизмыг бий болгох зорилтын хүрээнд (4.3)	• Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх чиглэлээр хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах зорилтын хүрээнд (4.4)	• Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, зорилтот бүлгийн иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд(4.5)	• Эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийг боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд тэгш хамруулах ажлыг уялдуулан зохион байгуулах зорилтын хүрээнд (4.6)
• АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хөгжүүлэх эрэлт хэрэгцээг харгалзан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах; • АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний нэгдсэн стандарт боловсруулж, хэрэгжүүлэх.	• Оролцогч талууд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, тус санамж бичигт талуудын үүрэг оролцоог нарийвчлан тусгаж өгөх; • Боловсролын байгууллагын удирдлага, менежер, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд суралцах чиглэл, АМЧБО, ХЗЗ-ийн талаарх зөвлөгөө, мэдээллээр	• Багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт АМЧБО агуулгыг тусгах; • ЕБС-ийн ахлах анги удирдсан багш, насан туршийн боловсролын төвийг багш нарыг суралцах чиглэл, АМЧБО арга зүйд сургах; • Хөдөлмөр эрхлэлтийн албаны мэргэжилтнүүд, боловсролын бүх шатны байгууллагын нийгмийн ажилтан, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан, иргэний нийгмийн байгууллагын холбогдох ажилтнуудыг үе	• Зорилтот бүлгийн иргэнд ажил, мэргэжлээ сонгох, ажил хайх, ажил мэргэжлээрээ өсөж хөгжих, хувь хүний хөгжил, төлөвшил болон сэтгэл зүйн сургалтыг тогтмол, үе шаттай, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүргэх; • Оюутан, сурагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, дадлагажих нөхцөлийг бүрдүүлэх замаар ажил мэргэжилтэй бодитой танилцах боломжийг нэмэгдүүлэх; • Албан бус насан туршийн боловсролын төв, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын дэргэдэх иргэн, оюутанд	• Хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгууллагаар дамжуулан МЧБО үйлчилгээ үзүүлэх; • Нийгмийн халамж, тусалцаа зайлшгүй шаардлагатай гэр бүл, гэр бүлийн гишүүнд АМЧБО, зөвлөгөө өгөх үйлчилгээг орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; • ХБИ, хорих ангид хүмүүжигч,

	хангах чиг үүргийг тусгах; - Боловсрол, мэргэжил, ХЗЗ-ийн цогц бөгөөд уялдаа холбоо бүхий мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх; - Хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарын бодлого төлөвлөлтөд ХЗЗ-ийн судалгаа мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх; - Жилд нэг удаа холбогдох яамд, хувийн хэвшил, ТББ-ууд хамтран дэд чуулга уулзалт зохион байгуулах.	шаттай сургалтад хамруулж мэргэшүүлэх; - АМЧБО сургагч багш нарт зориулсан цахим мэдээллийг хөгжүүлж, арга зүйн гарын авлагаар хангах; - АМЧБО төрийн болон ТББ-ын холбогдох мэргэжилтнүүдийг дотоод, гадаадад туршлага судлах, танилцах аялал хийх замаар мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	үйлчлэх төвүүд зэрэг хөдөлмөр эрхлэлт, боловсролын үйлчилгээг дэмжих бүтцийг оновчтой ашиглаж, АМЧБ-ны хүртээмжийг өргөжүүлэх; - Ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээний загвар төвийг байгуулахыг дэмжиж, тухайн орон нутгийн иргэн ажил мэргэжлээ зөв сонгох, ХЗЗ-д идэвхтэй оролцоход туслалцаа, дэмжлэг үзүүлэх; - Техник технологийн дэвшилтэт шинэлэг хэлбэрүүдийг ашиглан АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг цахим хэлбэрээр иргэнд хүртээмжтэй хүргэх боломжийг нэмэгдүүлэх; - Зорилтот бүлэгт зориулсан ном, гарын авлага боловсруулах; - АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, иргэдийг мэргэшсэн зөвлөх/мэргэжилтнээс үйлчилгээ авах соёлд сургах.	хорих ангиас суллагдсан иргэдийн онцлогт тохирсон АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх; Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын сурагчдыг АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулах.
Үр дүн				
АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсон байна. АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний нэгдсэн стандарт бий болсон байна.	Хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан байна. Холбогдох талууд АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлдэг болсон байна. Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна. Дэд чуулга уулзалт зохион байгуулагдсан байна.	Багш бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт АМЧБО агуулгыг тусгасан байна. ЕБС-ийн дунд болон ахлах анги удирдсан багш нарыг суралцах чиглэл, АМЧБО арга зүйд сургасан байна. АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ цар хүрээ өргөжиж, хүртээмж нэмэгдсэн байна. АМЧБО ажилтны мэргэшил,	Зорилтот бүлгийн иргэд сургалтад хамрагдсан байна. Сурагчид, оюутнууд суралцах болон ажиллах сонголт хийхээсээ өмнө тэдгээрийг судлах, турших, танилцах боломж бүрдсэн байна. Албан бус Насан туршийн боловсролын төв, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын дэргэдэх оюутанд үйлчлэх төвүүд дэх мэргэшсэн зөвлөхөөс АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах	Нийгмийн хамгааллын байгууллагын холбогдох ажилтан АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлдэг болсон байна. Холбогдох орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдэд хүрэх хөдөлмөр

	Боловсрол, ур чадвар, ажил мэргэжлийн үл нийцлээс үүдэлтэй ажилгүйдэл буурна	мэргэжил, ур чадвар дээшилсэн байна. АМЧБО зөвлөх мэргэжилтнийг бакалавр ба дээш түвшинд бэлтгэж эхэлсэн байна. АМЧБО зөвлөх, сургагч багш нарт зориулсан цахим болон хэвлэмэл гарын авлагатай болсон байна. Холбогдох мэргэжилтнүүд мэдлэг, ур чадвараа хөгжүүлсэн байна.	үйлчилгээ авах хүртээмж нэмэгдэнэ. АМЗ үйлчилгээний загвар төвүүдийн тоо нэмэгдсэн байна. Иргэд техник технологийн дэвшилтэт шинэлэг хэлбэрүүдийг ашиглан орон зай, цаг хугацаа харгалзахгүй хэрэгцээтэй мэдээллээ авна. Зорилтот бүлэгт зориулсан ном, гарын авлага гарсан байна. Иргэд АМЧБ-ны мэргэшсэн зөвлөхөөс мэдээлэл, зөвлөгөө авах соёлд суралцсан байна.	эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. Эмзэг эрсдэлтэй болон нийгмээс тусгаарлагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
--	--	--	---	---

ХХҮЕГ-ын даргын А/179 тоот тушаал - 2017.06.23

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж Аймаг, нийслэл, дүүргийн эрх бүхий хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтан, албан хаагчид АМЧБО, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, ХЗЗ-ийн мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд нэгдсэн зохион байгуулалттайгаар хүргэхэд энэхүү зөвлөмжийг арга зүйн удирдлага болгоно			
АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд үзүүлснээр дараах үр дүнд хүрэх юм - Зорилтот бүлгийн иргэдийг ХЗЗ-ийн мэдээ, мэдээллээр хангах - Тэдэнд шаардлагатай зөвлөх үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх - Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх			
Үйлчилгээний чиглэл	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн агуулга	Үйлчилгээг үзүүлэх хэлбэр	Хэнд энэ үйлчилгээг үзүүлэх вэ?
АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - Тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, - Ажил, мэргэжлээ сонгох - Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийн талаар зөвлөгөө өгөх - Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах нөхцөл, боломжийн талаар зөвлөгөө өгөх	- ХЗЗ-ийн бүтэц, чиг хандлага - Эдийн засгийн салбар болон ажил мэргэжлийн хандлага - Ажил мэргэжлийн бүрэлдэхүүн болон чадварын эрэлт хэрэгцээ суралцах боломжууд - Эдийн засаг дахь ажлын боломж - Өөрөө өөртөө ажлын байр хэрхэн бий болгох - Ажиллах хүчний дотоод, гадаад шилжин суурьшилт - Мэдээллийг хэрхэн олж авах /интернэт ашиглах, өөрөө	- АМЧБО бүлгийн зөвлөгөө, сургалт - Тухайн иргэний хэрэгцээг тодорхойлон үзүүлэх сургалт, зөвлөгөөний төрлийг сонгоно. Зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагад үндэслэн ижил төстэй байдлаар нь иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулан зөвлөгөө өгнө. - Хугацаа 80мин ихгүй байна - АМЧБО ганцаарчилсан зөвлөгөө, сургалт - Хувь хүний авьяас, сонирхол, чадварын үнэлгээг хийх - Ажилд орох ярилцлага өгөх, - Ажил олгогчтой харилцах, - Анкет бөглөх	- Ажилгүй иргэд - Ажил хайгч иргэн - Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн - Ажил олоход хүндрэлтэй иргэн - Их дээд сургууль, коллежийн оюутан - МБСБ, мэргэжлийн сургалтад суралцагчид - ЕБС-ийн ахлах ангийн сурагч

ХЗЗ-ийн мэдээллээр хангах зэрэг үйлчилгээ багтана.	өөртөө үйлчлэх систем/	- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа мэргэжил, ур чадвар, ажлын байрны захиалгын талаар мэдээлэл өгөх - Хугацаа 30-40 мин	
Үйлчилгээг үзүүлэхэд мөрдлөг болгон ажиллах баримт бичгүүд		Хэн энэ үйлчилгээг үзүүлэх вэ?	
- ХХҮЕГ-аас баталсан хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын үйл ажиллагааны гарын авлага, - АМЧБО сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр Арга зүйн зөвлөмж		- Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага - Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, алба - Хөдөлмөрийн хувийн бирж *Мэргэшсэн зөвлөхийн эрх авсан хөдөлмөрийн ажилтан	

Хөдөлмөрийн салбарт мөрдөгдөж журмуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний агуулга, зорилтот бүлгийг тодорхойлсон байдал

№	Эрх зүйн баримт бичгүүд	Агуулга	Зорилтот бүлэг	Хүргэх хэлбэр/цаг
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	- Тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, - Ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, - Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах	*Тусгаагүй	- ганцаарчлан болон - хэсэг, бүлгээр зохион байгуулна
2	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж /ХХҮЕГ А/179 2017.06.23/	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, - ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах нөхцөл, боломжийн талаар зөвлөгөө өгөх, - хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах зэрэг үйлчилгээ багтана.	1. Ажилгүй иргэд 2. Ажил хайгч иргэн 3. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн 4. Ажил олоход хүндрэлтэй иргэн 5. Их дээд сургууль, коллежийн оюутан 6. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтад суралцагчид 7. ЕБС-ийн ахлах ангийн сурагч	- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө, сургалт – 80 минутаас ихгүй байх - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө, сургалт – 30-40 минут
3	Ажил мэргэжлийн баримжааг хөгжүүлэх чиглэл Хөдөлмөрийн сайд, БСШУ сайдын А165/А266	- Хүүхэд, залуучууд (1.2.1); 1. ЕБС-ийн ахлах ангийн суралцагч, 2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч 3. Их, дээд сургууль, коллежийн оюутан; 4. Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн; 5. Эцэг эх, асран хамгаалагчид; - Насанд хүрэгчид (1.2.2);		

	хамтарсан тушаал	6. Ажил хайгч иргэн 7. Хугацаат цэргийн албан хаагч 8. Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэн 9. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэн 10. Тэтгэврийн насны иргэн • Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн (1.2.3) 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 12. Эмзэг эрсдэлтэй бүлгийн иргэн 13. Хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэн
4	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр агуулга/ХХҮЕГ А/249 2017.09.25	Сургалтын жишиг хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлэг бүрд 3 модуль сургалтын агуулгыг томьёолсон. 1. ЕБС-ийн ахлах ангийн сурагчид /VIII-XII/ 2. Мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагч 3. Их, дээд сургууль, коллежийн оюутан 4. Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн 5. Ажил хайгч иргэн 6. Хугацаат цэргийн алба хаагч 7. Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирсэн иргэн 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 9. Эмзэг, эрсдэлтэй бүлгийн иргэн 10. Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн

- Зорилтот бүлгийн агуулга бүр 8 акцагийн багтаамжтай

Боловсролын салбарт хэрэгжиж байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа дараах журмуудаар зохицуулагдаж ирсэн байна.

- Засгийн газрын 2013 оны 295-р тогтоолоор батлагдсан “Зөв Монгол хүүхэд хөтөлбөр”-ийн “Авьяас” дэд хөтөлбөрийн хүрээнд: 7.2.2 хүүхдийн авьяас чадвар тулгуурлан сурах арга барил, МЧБ эзэмшүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулна”
- БСШУ-ны сайдын 2015 оны 424-р тушаалаар Ахлах ангид шинэчилсэн хөтөлбөр турших чиглэл баталж “Зөвлөн туслах үйлчилгээ”-тэй байх тухай заасан байна.
- БСШУЯ-ны сайдын 2015.06.10-ны өдрийн А220-р тушаалаар баталсан Суурь боловсролын “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”-ны хөтөлбөр
- БСШУ-ны сайдын 2016 оны А/103 тоот тушаал, 2018 оны А/453 дугаар тушаалаар шинэчлэн баталсан ЕБС-ийн ахлах ангийн сургалтын шинэчилсэн төлөвлөгөө
- БСШУ-ны сайдын 2020.12.23 өдрийн А200 дугаар тушаалаар баталсан ЕБС-ийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэл
- БСШУЯ-ны 2022.08.17-ны өдрийн А288-р тушаалаар баталсан Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр

Боловсролын ерөнхий хууль

Боловсролын ерөнхий хууль - 2023.07.07	
Боловсролын зорилго (4)	Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах , ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино. (4.1.)
Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгаж боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ (14.4)	1. Монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, төлөвшил (14.4.1) 2. Хувь хүн, гэр бүлийн төлөвшил, амьдрах ухаан, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл (14.4.2); 3. Хүний эрхийн боловсрол, жендерийн эрх тэгш байдал (14.4.3) 4. Иргэний ёс зүйн болон зан төлөвийн боловсрол (14.4.4) 5. Эрүүл мэндийн боловсрол (14.4.5)

	6. Хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол (14.4.6) 7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухаан (14.4.7) 8. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох (14.4.8) 9. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүний хор уршиг, дэлгэцийн донгоос сэргийлэх талаар (14.4.9)
Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль – 2023.07.07	
Ерөнхий боловсролын зорилго (3)	Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.(3.2)
Ерөнхий боловсролын агуулга	Энэ хуулийн 3.2-т заасан боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.
Сургалтын хөтөлбөр (10)	Ахлах ангийн сургалтын хөтөлбөр нь заавал болон сонгон судлах хэлбэртэй байна. (10.9)
Ерөнхий боловсролын сургууль (20)	Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, АМЧБО-д чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ЕБС-ийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна (20.10.)
Суралцагчийн эрх (12)	Өөрийн авьяас чадвараа хөгжүүлэх, сурлагын амжилтаа ахиулахад чиглэсэн дэмжлэг авах; (12.1.3)
Багшийн ажил үүрэг (15)	Суралцагчийн мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх; 15.1.3 Хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах. 15.1.6
Удирдах болон бусад ажилтны үүрэг (17)	ЕБС-ийн нийгмийн ажилтан сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих, АМЧБО, эрсдэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг суралцагч, тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үзүүлнэ (17.3)
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль (2023)	
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго (4)	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино. (4.1)
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын агуулга, хөтөлбөр (6)	Техникийн боловсролын агуулгыг суралцагчид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, техник, технологийн үйл ажиллагааг удирдах, гүйцэтгэх чадамж, хувиараа хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшүүлж, мэргэжил олгох чиглэлээр тогтооно. (6.3)
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим (5)	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаанд(5.1) хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжлийг дэмжсэн байх. (5.1.4)
Дээд боловсролын тухай хууль (2023)	
Дээд боловсролын зорилго (2)	Дээд боловсролын зорилго нь нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино. 2.1
Сургалтын хөтөлбөр агуулга (20)	Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна доор дурдсан агуулгыг тусгана: 20.5 мэргэших хэсэгт тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тухайн салбар, чиглэлийн шинжлэх ухаан, арга технологи. 20.5.3
17 дугаар зүйл.Боловсролын байгууллага	17.6.Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан

	туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд байна
БШУ-ны сайдын А/288 тоот тушаал 2022.08.17	ЕБС-ийн сургуулийн хичээлээ

ЕБС-ийн ажил мэргэжлийн чиг баримжааны талаарх БСШУЯ-ны санаачилга⁵

2015-17: БСШУСЯ нь ЕБС-ийн 8, 9 дүгээр ангид АМЧБ-ны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тэр дундаа 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн "Сонголтын 7 хоног"-ийн үйл ажиллагааг бүх сургуульд зохион байгуулсан байдаг. Энэ үйл ажиллагаатай холбоотой ЕБС-ийн удирдлага, 8, 9 дүгээр ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө боловсруулж төрийн өмчийн бүх сургуулиудад түгээсэн байна.

2018-19: БСШУСЯ нь ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдад чиглэсэн АМЧБ-ны үйл ажиллагааг хэрэгжүүлэх санаачилга гаргаж, холбогдох удирдамж, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулж байна. Үүнтэй холбогдуулан ЕБС-ийн удирдлага, ахлах ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө, хөтөч боловсруулж, төрийн өмчийн бүх сургуульд түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Энэ үйл ажиллагаа 2018- 2019 оны хичээлээс жилээс эхлэн бүх сургуульд хэрэгжинэ

Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу вэ?

Ажил мэргэжлийн чиг баримжаа нь эцэг эх, суралцагчдад ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон их дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг үйл ажиллагаа юм.⁶

Ажил мэргэжлийн баримжаа олгох сургалтын зорилго	Чадамж	Мэдлэг чадвар
- Өөрийн сонирхол, авьяас, чадвар, эрхэмлэх үнэт зүйлд тулгуурлан ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө ухаалгаар сонгоход дэмжлэг үзүүлэх - Сургууль төгссөний дараах ажил мэргэжил, боловсрол, сургалтын боломж, сонголт, түүнтэй холбоотой хэрэгцээ, шаардлагын талаар мэдлэг эзэмшүүлэх - Сургалт болон ажил мэргэжлийн дунд, богино болон урт хугацааны төлөвлөгөө хийх, зорилго тодорхойлох, түүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Ажил мэргэжлийн шийдвэрээ хэрхэн үйл хэрэг болгон хэрэгжүүлэх, энэ шийдвэртээ холбогдох мэдээлэл ашиглан үнэлгээ дүгнэлт өгөх, ахлах ангид хийх шилжилт болон сургууль төгссөний дараа их, дээд сургуульд сурах шилжилтээ үр дүнтэй удирдах; - Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлахад дэмжлэг үзүүлэх - Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход	10 дугаар анги 9-р ангид хийсэн сонголтоо эргэн харах, дахин дүгнэх 9-р ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах - Ажил мэргэжлийн талаар илүү бодитой ойлголттой болох - Ирээдүйгээ төсөөлөх - Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлах 11 дүгээр ангид судлах хичээл, хөтөлбөр сонгох 11 дүгээр анги 10 дугаар ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах - Дээд боловсрол, МБС, ХЗЗ-ийн сонголтоо хийх - Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх - Дээд боловсрол, МБС-ын талаар түр хугацааны шийдвэр гаргах - Аль их сургуульд элсэх талаар түр хугацааны шийдвэр гаргах сайжруулах 12 дугаар анги	- Ажил мэргэжлийн сонирхлын талаарх мэдлэг - Ажил мэргэжил, ажлын ертөнц, тодорхой ажил мэргэжилд тавигдах хувь хүний болон мэргэжлийн шаардлага, энэ ажил мэргэжлийг эзэмших боловсрол, сургалтын боломж болон ажил хайх арга замын талаарх мэдлэг - Бүх төрлийн сургалтын (өдрийн, эчнээ, оройн, зайны болон цахим сургалтын) сонголтын талаарх мэдээлэл - Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалт болон зайны болон цахим сургалтын хөтөлбөрийн агуулга - Тухайн хөтөлбөрөөр суралцаж эзэмших мэргэжил, мэргэшил сургууль, мэргэжлийн боловсрол, сургалт болон зайны болон цахим сургалтын хөтөлбөрийн агуулга - Сургалтын хугацаа, зардлын талаарх мэдлэг

5 "Ажил мэргэжлийн чиг баримжаа" эцэг эх, асран хамгаалагчид зориулсан зөвлөмж, 2018, 6 хуудас

6 "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь" сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, 2018, 3 хуудас

өөрийгөө бэлтгэх, түүнээс гарах арга замыг мэдэхэд туслах Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргаж сурахад дэмжлэг үзүүлэх⁷	11 дүгээр ангид хийсэн ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө эргэж харах, - Дээд боловсролын байгууллагад суралцах өргөдөл гаргах бэлтгэх - Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх - МБС-ын байгууллагад суралцах өргөдөл гаргах - Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргах⁸	7. Тухайн хөтөлбөрийг дүүргэсний дараа ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаарх мэдлэг 8. Ажилгүй нөхцөл байдлыг хэрхэн удирдахтай холбоотой мэдлэг чадвар 9. Ажил хэрхэн хайх тухай мэдлэг 10. Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхдээ яаж, хаанаас мэдээлэл олох тухай мэдлэг
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын хэлбэр, зохион байгуулалт		
Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа		Сургуулиас гадуурх үйл ажиллагаа
Сургууль бол ажил мэргэжлийн танхимын үйл ажиллагааг зохион байгуулах хамгийн тохиромжтой газар. Учир нь суралцагчдыг бүлгээр зохион байгуулж ажил мэргэжлийн чиг баримжааг илүү системтэй, зохион байгуулалттай хэрэгжүүлэх боломжтой юм.⁹ 1. Сургуульд суурилсан хөтөлбөр 2. Ангид суурилсан хөтөлбөр¹⁰ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийг сургуулийн удирдлага эцэг эх, суралцагчидтай хамтран боловсруулна.¹¹ Тус хөтөлбөрийг ангийн багш, нийгмийн ажилтан хамтран хэрэгжүүлнэ.		Ажлын туршлага хуримтлуулах, ажлын байранд зочлох, боловсролын яармагт очих, хөдөлмөр эрхлэлтийн яармагт зочлох г.м - Цагийн ажил - Сайн дурын үйл ажиллагаа - Ажлын туршлага хуримтлуулах үйл ажиллагаа - Хөгжим, спорт, бүжиг, урлагийн дугуйлан, секц г.м

БСШУ-ны сайдын А/200 тоот тушаал - 2020.12.23

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны чиглэл			
Зорилго	Суралцагч өөрийгөө танин мэдэх, ирээдүйн зорилгоо тодорхойлох, өөрийн боломж, чадвартаа тохирсон ажил мэргэжлээ зөв сонгох, сурах үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг нэвтрүүлэхэд оршино.		
Зорилт	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хүний нөөцийг үе шаттай Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ, үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын нийгмийн түншлэлийг бий болгох		
Үйл ажиллагаа			
АМЧБО үйлчилгээг ЕБС-д хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд	АМЧБО хүний нөөцийг үе шаттай бэлтгэх	АМЧБО үйлчилгээ, үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд	Төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодын нийгмийн

7 “Ажил мэргэжлийн чиг баримжаа” ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном, 2018, 7 хуудас

8 “Ажил мэргэжлийн чиг баримжаа” ЕБС-ийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном, 2018, 8 хуудас

9 “АМЧБО үйл ажиллагааг төлөвлөх нь” сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, 2018, 6 хуудас

10 Мөн тэнд

11 Мөн тэнд

	чадавхжуулах зорилтын хүрээнд		түншлэлийг бий болгох зорилтын хүрээнд
- АМЧБО үйл ажиллагааг боловсролын бодлого, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгах (1.1) - Ахлах ангийн хичээл, хөтөлбөрийн сонголт нь ажил мэргэжлийн сонголтод үндэслэн хийгдэх учраас сургалтын төлөвлөгөөнд Х ангид 12 цаг, XI ангид 12 цаг, XII ангид 10 цагаас доошгүй байхаар төлөвлөж журамд тусгах (1.2) - Багш, нийгмийн ажилтныг үнэлэх үнэлгээний журамд тусгах (1.3) - Багш, удирдах ажилтны ажлын байрны тодорхойлолтод АМЧБО үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг тусгах (1.4)	- АМЧБО үйл ажиллагааны агуулга, хөтөлбөрийн жишиг загварыг боловсруулах (2.1) - Багш удирдах ажилтанд мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах (2.2)	- Нийслэл болон орон нутгийн Боловсрол, соёл урлагийн газар нь мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх "АМЧБО мэдээллийн танхим"-ыг Насан туршийн боловсролын үндэсний төв, 21 аймаг, 8 дүүрэгт байгуулах (3.1) - Багш, суралцагч, эцэг эхэд АМЧБО цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх(3.2) - ЕБС-иудад АМЧБО үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэглэгдэхүүнээр хангах (3.3) - АМЧБО үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй болгох (3.4) - Тухайн орон нутаг болон сургуулийн онцлогт тулгуурлан АМЧБО үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжит хувилбаруудыг санал болгох (3.5) - Ахлах ангийн хичээл, хөтөлбөрийн сонголт нь ажил мэргэжлийн сонголтод үндэслэн хийгдэх учраас сургалтын төлөвлөгөөнд Х ангид 12 цаг, XI ангид 12, XII ангид 10 цагаас доошгүй байхаар төлөвлөж оруулах (3.6) - Тусгай хэрэгцээт болон насан туршийн боловсролын төвийн суралцагч, иргэдэд АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамруулах (3.7)	- АМЧБО үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх салбар дундын зөвлөл үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулах (4.1) - АМЧБО үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад мониторинг хийх (4.2) - АМЧБО үйлчилгээ, үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх (4.3).
Хамрах хүрээ	ЕБС-иар дамжуулан АМЧБО үйл ажиллагаа нь ЕБС-ийн суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш, төвийн болон орон нутгийн төрийн захиргаа, удирдлага, арга зүйн байгууллага болон ТББ, ААН байгууллагууд		

Боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын агуулгыг харьцуулсан байдал

Зорилтот бүлэг	Хөдөлмөр эрхлэлтийн салбарын агуулга		Боловсролын салбарын агуулга	
	Зорилго	Модуль	Зорилго	Мэдлэг
ЕБС-ийн ахлах ангийн суралцагч /8-12 дугаар анги/	Зорилго: Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын талаарх ойлголтыг төлөвшүүлэх, мэргэжил сонголтын арга аргачлалыг эзэмшүүлэх	Модуль-1 Мэргэжлээ зөв сонгож ирээдүйнхээ эзэн болох нь – 2 ак.цаг Модуль-2 Надад ямар мэргэжил тохирох вэ? – 4 ак.цаг Модуль-3 Сургуулиа сонгох нь – 2 цаг	- Өөрийн сонирхол, авьяас, чадвар, эрхэмлэх үнэт зүйлд тулгуурлан ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө ухаалгаар сонгоход дэмжлэг үзүүлэх - Сургууль төгссөний дараах ажил мэргэжил,	10 дугаар анги 9-р ангид хийсэн сонголтоо эргэн харах, дахин дүгнэх 9-р ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч	Зорилго: Сургуулиа төгсөхөөсөө өмнө ажлын байранд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, ажиллах чиг баримжаатай болгох, өөрийгөө болон байгууллагаа ойлгох чадвар эзэмших	Модуль-1 Ирээдүйгээ төлөвлөж өөрийгөө бэлтгэх нь – 4 ак.цаг Модуль-2 Ажилдаа дасан зохицож өөрийгөө хөгжүүлэх нь – 4 ак.цаг	боловсрол, сургалтын боломж, сонголт, түүнтэй холбоотой хэрэгцээ, шаардлагын талаар мэдлэг эзэмшүүлэх - Сургалт болон ажил мэргэжлийн дунд, богино болон урт хугацааны төлөвлөгөө хийх, зорилго тодорхойлох, түүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; - Ажил мэргэжлийн шийдвэрээ хэрхэн үйл хэрэг болгон хэрэгжүүлэх, энэ шийдвэртээ холбогдох мэдээлэл ашиглан үнэлгээ дүгнэлт өгөх, ахлах ангид хийх шилжилт болон сургууль төгссөний дараа их, дээд сургуульд сурах шилжилтээ үр дүнтэй удирдах; - Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлахад дэмжлэг үзүүлэх - Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх, түүнээс гарах арга замыг мэдэхэд туслах Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргаж сурахад дэмжлэг үзүүлэх¹²	- Ажил мэргэжлийн талаар илүү бодитой ойлголттой болох - Ирээдүйгээ төсөөлөх - Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлах 11 дүгээр ангид судлах хичээл, хөтөлбөр сонгох 11 дүгээр анги 10 дугаар ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах - Дээд боловсрол, МБС, ХЗХ-ийн сонголтоо хийх - Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх - Дээд боловсрол, МБС-ын талаар түр хугацааны шийдвэр гаргах - Аль их сургуульд элсэх талаар түр хугацааны шийдвэр гаргах сайжруулах 12 дугаар анги 11 дүгээр ангид хийсэн ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө эргэж харах, - Дээд боловсролын байгууллагад суралцах өргөдөл гаргах бэлтгэх - Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх - МБС-ын байгууллагад суралцах өргөдөл гаргах Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргах¹³
Их дээд сургууль, коллежийн оюутан	Зорилго: Төгсөхөөсөө өмнө ажлын байранд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, ажиллах чиг баримжаатай болгох, өөрийгөө болон байгууллагаа ойлгох чадвар эзэмшсэн байх	Модуль-1 Ажил хөдөлмөрт өөрийгөө бэлтгэх нь – 2 ак.цаг Модуль-2 Ажлын ертөнц рүү алхан орох үе – 2 ак.цаг Модуль-3 Ажилдаа эзэн болох нь – 2 ак.цаг		
Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн	Зорилго: Нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэх, сэтгэл зүйн бэлтгэлийг хангах, суралцах чиг баримжаатай болгох, өөрийгөө болон бусдыг ойлгох эерэг хандлага, харилцааны ур чадварыг эзэмшсэн байх	Модуль-1 Би амьдралынхаа төлөө юу хийж чадах вэ? – 3 ак.цаг Модуль-2 Харилцаа холбоогоо бэхжүүлэх нь – 3 ак.цаг Модуль-3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд танд ямар боломжууд байгаа болон хэрхэн ашиглах вэ? – 2 ак.цаг		
Дүгнэлт	Жишиг хөтөлбөрт агуулгыг хэт ерөнхий байдлаар тусгасан бөгөөд цаашид зорилтот бүлгийн иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн агуулгыг боловсруулах нь тус үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагуудад ач холбогдолтой юм.		Агуулгыг анги бүрээр тодорхойлсон боловч агуулгын хүрээ зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцээгүй байна. Цаашид тус хөтөлбөрийн агуулгыг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэх шаардлагатай байна.	

3.5 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний оролцогч тал

12 “Ажил мэргэжлийн чиг баримжаа” ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчийн дасгал ажлын ном, 2018, 7 хуудас

13 Мөн тэнд, 8 хуудас



3.6 Хүний нөөцийн чадавх

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд үзүүлж байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах үйлчилгээг улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөрийн газар/хэлтсүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтнүүд хүргэж байна. Сум, хороонд тус үйлчилгээг хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн үзүүлэхээр зохицуулагдсан байна. Мөн тус үйлчилгээг хөдөлмөрийн хувийн биржүүд гэрээлэн гүйцэтгэж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны тоо мэдээгээр сум хороонд хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 456, аймаг, дүүрэгт хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн 97, ахлах мэргэжилтэн 14 ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтний тоон мэдээлэл


	Нийт	Дарга	Ахлах мэргэжилтэн	Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Архангай	25			5	20
Баян-Өлгий	15	1	1		13
Баянхонгор	25	1	2	4	18
Булган	22	1	2	3	16

	Нийт	Дарга	Ахлах мэргэжилтэн	Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Говь-Алтай	26	1	1	3	21
Говьсүмбэр	8	2			6
Дархан-Уул	15	1	1	3	10
Дундговь	15			1	14
Дорнод	11		1	2	8
Дорноговь	14	1		4	9
Завхан	27			3	24
Орхон	20	1		9	10
Өвөрхангай	27	1	1	7	18
Өмнөговь	7		2	4	1
Сүхбаатар	11			1	10
Сэлэнгэ	24	1		5	18
Төв	31	1	1	1	28
Увс	23			4	19
Ховд	23	1	1	6	15
Хөвсгөл	30			2	28
Хэнтий	19	1	1	5	12
Улаанбаатар хотын 9 дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс					
БГД	35	1		5	29
БЗД	49	1		5	43
СБД	19			4	15
СХД	23	1		1	21
ЧД					
ХУД	22	1		2	19
БНД	8	2		2	4
БХД	5	2		3	
НД	11	1		3	7
Нийт	590	23	14	97	456

Боловсролын салбарт тус үйлчилгээг бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэхээр Боловсролын ерөнхий хууль(2023 он)-д заасан байдаг. Улсын хэмжээнд 2022-2023 оны байдлаар Ерөнхий боловсролын сургууль-695, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль-48, их, дээд сургууль-16 буюу нийт 1011 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнд ерөнхий боловсролын сургуульд 37.000, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль 2400 багш, их, дээд сургуульд 5100 багш ажиллаж байна.

Боловсролын сургалтын байгууллагын тоо мэдээ¹⁴

¹⁴ Боловсрол шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээлэл 2024, 20 хуудас



Боловсролын салбарын багш, ажиллагчдын тоо мэдээ. мянган хүн¹⁵



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг нь хүний нөөцийн чадавхаар тодорхойлогддог. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх талаар хийгдсэн ажлыг тоймлон авч үзье.

Хөдөлмөрийн салбарт 2009-2018 оны хооронд давхардсан тоогоор 3 үе шаттай сургалтад 1200 гаруй хүнийг ажил мэргэжлийн зөвлөхөөр, 42 хүнийг сургагч багшаар бэлдсэн байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Ашигт малтмалын түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол” төслийн хүрээнд 2013-2018 оны хооронд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх сургалтуудыг 3 үе шаттай зохион

¹⁵ Мөн тэнд, 23 хуудас


¹⁶ Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн холбооны тэргүүн Ш.Сосорбарамын илтгэлээс, 2019 он

байгуулсан. Үүнд хөдөлмөр болон боловсролын салбарын 15 байгууллагын 268 албан хаагч хамрагдсан байна. Мөн тус төслийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгаалалтын яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Монгол улсын их сургуулийн хамтран хэрэгжүүлсэн Ажил мэргэжил судлалын магистрын хөтөлбөрт 2017-2023 оны хооронд 60 магистр суралцаж төгссөн байна.

Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн ажил мэргэжлийн чиг баримжаа, ажил зуучлал хариуцсан мэргэжилтний мэргэшсэн байдлын судалгааг 2018 онд хийсэн. Тус судалгаанд давтагдсан тоогоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох анхан шатны сургалтад-28 хүн, дунд шатны сургалтад- 27 хүн, ахисан шатны сургалтад -5 хүн хамрагдсан байна. Үүнээс ажил үүргээ тогтвортой гүйцэтгэж байгаа 32 хүн байна¹⁷.

Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төслийн “Арга зүйн дэмжлэг үзүүлэх” багийн 2022 оны тайланд тусгаснаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрагдсан 48 алба хаагч, ажил зуучлалаар чадавхажсан 14 алба хаагч ажиллаж байна. ¹⁸

Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтний сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэхээр бүртгүүлсэн 101 хөдөлмөрийн биржээс 2024 оны байдлаар 42 бирж идвэхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Идвэхтэй үйл ажиллагаа явуулж буй хөдөлмөрийн биржүүдийн мэдээлэл

№	Биржийн нэр	Үүсгэн байгуулсан огноо	Зөвшөөрөл авсан огноо	Ажилтны тоо
1	Ялгуусан сор ХХК		23/04	2
2	Жи Ди Эс Эйч ХХК		23/08	
3	Их үйлсийн бүтээмж ХХК	2019	23/13	4
4	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ	2016	23/14	3
5	Монголын удирдлага шинэчлэл менежментийн академи НҮТББ	2019	23/18	4


¹⁷ ХХҮЕГ, 2018 оны судалгаа, Н.Алтансүвд

¹⁸ UNDP, Хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төслийн “Арга зүйн дэмжлэг үзүүлэх баг”-ийн тайлан, 2022 он

№	Биржийн нэр	Үүсгэн байгуулсан огноо	Зөвшөөрөл авсан огноо	Ажилтны тоо
6	Юнаятад карьер консалтинг ХХК	2020	23/19	10
7	Мэргэшсэн мэргэжил сургалтын төв	2020	23/25он	3
8	Оюуны чадамж хөгжил НҮТББ		22/06-24-26.04.19	
9	Амжилт боломж гарц НҮТББ		22/35	
10	Анар алдар ХХК	2022	22/22-24-26.04.19	13
11	Монголын экспорт, импортыг дэмжих үндэсний төв		22/16-24-26.04.19	
12	Шинэ хөгжлийн түлхүүр ТББ			
12	Ирмүүн төгс ХХК		22/14-24-26.04.19	
13	Мөнх ирээдүйн ундарга ХХК-ийн дэргэдэх ХБ		24/01	
14	Вест метод ХХК-ийн дэргэдэх ХБ	2011	24/02	6
15	Их номч мэлмий ХХК	2020	24/03	4
16	Монголын хүний нөөцийн менежментийн холбоо НҮТББ	2004	24/04	2
17	Алтан алхам ТББ	2018	24/05	2
18	Монгол хүн хөгжлийн тулгуур НҮТББ	2020	24/06	3
19	Дарь овооны эзэд ТББ	2018	24/07	5
20	Цогцлох ирээдүй НҮТББ	2017	24/08	4
21	Эрх зүйн хөтөч холбоо НҮТББ	2016	24/09	5
22	Эйч ар бридж ХХК	2017	24/10	4
23	Дэлгэрэх металл ХХК	2024	24/11	1
24	И Эм технологи ХХК		24/12	
25	Сонор эдүкейшн ХХК	2021 он	24/13	5
26	Ундармал оюун ухаан НҮТББ		24/14	
27	Дорнын хүчит шонхор ХХК		24/15	
28	Эл Эй Энд Си ХХК-ийн дэргэдэх ХБ	2015	24/	5
29	Итгэлт бүтээмж	2010	22/27-26 он хүртэл	6
30	Саруул-Ухаан ТББ	2018	24/16	2
31	Сантайн Сервис	2020	24/17	
32	Жоб көүчинг	2020	24/18	2
33	Эйч Ар Талант	2022	24/19	4
34	Жимбэгэр хайрхан		24/20	
35	Голден Бэмби	2020	24/21	
36	Арвин-Эрдэнэ ХХК РД 2622335	2003	22/09-26 он хүртэл	13
37	Техник тенологийн политехник коллеж	2017	22/28-26 он хүртэл	
38	Агаар мандал орчин ТББ	2017	22/31-24-26 он хүртэл	4
39	Ви Эс Эм ХХК	2022	22/30-26 он хүртэл	
40	Аребайт инлэг ХХК	2022	22/	17
41	Карьер мастер ХХК	2021	21/17- 26 он хүртэл	4
42	Дорнын гүүр ХХК	2011	22/11-26 он хүртэл	9

Боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хэрэгжүүлэх багш, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2018 онд Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулж, сургалтад нийт 2312 багш, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан болон МСҮТ-ийг төлөөлж захирал, нийгмийн түншлэлийн ажилтнуудыг оролцуулсан байна.¹⁹

ЕБС-ийн ахлах ангийн ажил мэргэжлийн чиг баримжааны сургагч багш бэлтгэх 5 хоногийн сургалтыг 2018 оны 6 болон 8 саруудад 2 хэсэгтэйгээр 25 сургагч багш бэлтгэжээ.



“Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх” бэлтгэх сургалтын агуулгад хийсэн шинжилгээ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх сургалтад 2013-2018 оны хооронд хөдөлмөр болон боловсролын салбарын 15 байгууллагын 268 албан хаагч хамрагдсан байна. Ажил мэргэжил судлалын магистрын хөтөлбөрийг 2017-2023 оны хооронд 60 магистр төгссөн байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлээр 2011 оноос эхлэн Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Мянганы сорилтын сан, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Швейцарын хөгжлийн агентлагийн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан 29 сургалтын хөтөлбөрийн агуулгад харьцуулсан шинжилгээ хийсэн болно.

ХХҮЕГ -ын даргын 2017 оны 10 сарын 06 өдрийн А/263 тоот тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох арга зүйн зөвлөмж, сургалтын агуулга” баталсан. Энэхүү тушаалаар ажилд зуучлалын мэргэжилтэнд 12 модулиар 5 хоног, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилтэнд 7 модулиар 5 хоног бэлтгэхээр заасан байна.

Дээрх 2 сургалтыг зохион байгуулах байгууллагын хувьд ажил зуучлалын мэргэжилтэнд бэлтгэх ерөнхий модулийг боловсруулсан байгууллага нь Хүний нөөцийн менежментийн холбоо, харин ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилтний ерөнхий модулийг боловсруулсан нь Монголын мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо буюу төрийн бус байгууллага байна.

¹⁹ ADB, Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төслийн тайлан, 2018 он

Нийт зохион байгуулагдсан сургалтыг цар хүрээ, давтамж, агуулга зэргээс нь дүгнэвэл анхан шат, дунд шат, ахисан шат гэсэн 3 түвшний сургалт явуулсан байна. Хугацааны хувьд анхан шатны сургалт 2-10 хоног, дунд болон ахисан шатны сургалт 3-10 хоногт зохион байгуулагдсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх сургагч багшийн сургалтыг 5-25 хоногийн хугацаатай зохион байгуулсан байна.

Эдгээр сургалтын агуулгыг зөвлөхийн сургалтад байвал зохих 9 агуулгын хүрээнд бүлэглэн, дараах шинжилгээг хийлээ. Үүнд онолын үзэл баримтлал, зөвлөгөө өгөх арга зүй, эрх зүйн орчин институтчилал, ажил мэргэжлийн мэдээллийн менежмент, зөвлөхийн чадвар, ёс зүй, зорилтот бүлгийн онцлог, оношилгоо, сургалт зохион байгуулах арга зүй, ажилд зуучлах агуулгууд орж байна. Практик ажилбарын агуулгад ганцаарчилсан дасгал ажил, багаар ярилцах буюу бүлгийн ажил, дадлага ажил буюу бие даан хэрэгжүүлэх гэсэн 3 ажилбарыг орууллаа.

Мөн А/263 тоот тушаалд заасан сургалтын модулийг


№	Сургалтын зохион байгуулалт									Сургалтын агуулга									Практикт ажил			нийт ак/ц
	Зохион байгуулагдсан сургалт	Зохион байгуулагдсан огноо	Сургалтын зохион байгуулагч	Хамтрагч/багш нар	Хамтрагч/багш нар	Сургалт зохион байгуулагдсан хугацаа	Сургалтын академик цаг	Сургалтын түвшин	Сургалтад хамрагдсан хүний тоо	Онолын үзэл баримтлал ак/ц	Зөвлөгөө өгөх арга зүй, техник ак/ц	Ажил мэргэжлийн мэдээллийн менежмент ак/ц	Зөвлөхийн ур чадвар, ёс зүй ак/ц	Зорилтот бүлгийн онцлог ак/ц	Эрх зүйн орчин институтчилал ак/ц	Сургалт зохион байгуулах арга зүй ак/ц	Оношилгоо ак/ц	Ажилд зуучлах ак/ц	Дасгал ажил /ганцаарчилсан	Бүлгийн ажил /багаар ярилцах	Дадлага ажил /бие даан хэрэгжүүлэх	
анхан шат																						
1	АМЧБ-ны зөвлөх бэлтгэх сургалт	2013	ХТБ	АМУЗХ		33	5	анхан шат	135		*	*	*		*	*	*					
2	АМЧБО зөвлөх бэлтгэх сургалт	2015.07	ХЯ	АМУЗХ		3		анхан шат	44		*	*	*			*	*		*	*		
3	АМЧБО зөвлөх бэлтгэх сургалт	2015.08	ОУХБ	АМУЗХ		5		анхан шат	28										*	*	*	
4	АМЧБО, мэргэжлийн зөвлөх бэлтгэх-1	2014.06.23	ГОУХАН		Ц.Амартөгс Рут М.Виссманн	5	32	түвшин 1	22		27	9.2	1	0.6	1.1	*	3.8		*	*		0.6
5	АМЧБО зөвлөхийн ур чадвар	2017.02	ГОУХАН	ССУТ	Б.Ууганцэцэг Ц.Энхжаргал Б.Алтанцэцэг	2		анхан шат	12	*	9.6		7			*	*					6.3
6	АМЧБО анхан шатны сургалт	2017.04	ГОУХАН	ССУТ		6		анхан шат	23	*	*		*			*	*					
7	АМЧБО зөвлөх бэлтгэх	2017.11	ГОУХАН	ММЗХ		5	36	анхан шат	16	*	*	*	*			*	*		*	*		
8	АМЧБО зөвлөх бэлтгэх сургалт	2017.12	ГОУХАН		АМЧБО сургагч багш нар	5		анхан шат	30	*	*	*	*			*	*		*	*		
9	АМЧБО мэргэшсэн зөвлөх бэлтгэх цогц сургалт	2020.07	Дундговь аймгийн ХХУГ	Өөрчлөлтийг чиглүүлэгч		6	60	анхан шат	16		*	*	*			*	*		*	*	*	
10	МЧБ	2011.06.13	ММСС		Рүберт Блум	10		анхан шат	12		*	*	*		*		*		*	*		
11	МЧБО зөвлөх бэлтгэх	2011.11.14	ММСС			5		анхан шат			*	*	*		*	*			*	*		
12	АМЧБ -1	2014.08.19	ГОУХАН		Ц.Амартөгс Ц.Нямсүрэн Т.Энхбаяр	3	24	анхан шат	15	2.6	8.5	0.3	2.6	3.5					*	*		5.7
13	АМЧБ -1	2014.08.20	ГОУХАН		Г.Бүдханд Д.Эрдэнэбилэг	3	24	анхан шат	15		13.8	2	1	1.5					*	*		4.7

14	АМЧБ -1	2014.09.09	ГОУХАН		Н.Энхзул Д.Оюунгэрэл	3	24	анхан шат	16		5.9	1.3	2.6	2.7					*	*		3.7
15	АМЧБ -1	2015.02.02	ГОУХАН		Ш.Сосорбарам	3	24	анхан шат	3	2.6	2.2		2.3	4.3					*	*		9.2
16	АМЧБ -1	2015.05.20	ГОУХАН		А.Амарзаяа Ц.Нармандах	4	24	анхан шат		1.3	4.6		5						*	*		11.7
17	АМЧБ -1	2015.06.29	ГОУХАН		С.Оюунсүрэн Г.Нямцэнд	4	25	анхан шат	25	2.5	6.5		4.3	2			*		*	*		6.9
18	АМЧБ -1	2015.06.30	ГОУХАН		Т.Оюунчимэг Т.Батжаргал Х.Цэцэгханд Ц.Батчимэг	3	25	анхан шат	18	2	6.9	*	1	3.9					*	*		6.7
дунд шат																						
1	МЧБО зөвлөх бэлтгэх-1	2011.12.05	ММСС		Д. Мөнхтогтох, Д.Ган-оюун, Ш.Сосорбарам, А.Амарзаяа, О.Энхбаяр	10		дунд шат	53		*	*	*		*	*		*	*	*	*	
2	АМЧБО, мэргэжлийн зөвлөх бэлтгэх-2	2014.07.01	ГОУХАН		Ц.Амартөгс, Рут М.Виссманн, М.Чимэддорж	3	24	түвшин 2	15		10.2	1	2.3	3.5					*	*		5.1
3	АМЧБ - мэргэжлийн түвшин	2015.04.13	ГОУХАН		С.Л.Пержол	5		мэргэжлийн түвшин	15	*	*	*	*		*	*	*		*	*		
4	АМЧБ -сургагч багш-2	2015.04.20	ГОУХАН		С.Л.Пержол	5	48	мэргэжлийн түвшин	16	*	*	*	*		*	*	*		*	*		
5	АМЧБО - зөвлөх бэлтгэх	2018.02	ГОУХАН	ММЗХ		3		дунд шат	47	*	*	*	*			*	*		*	*		
ахисан шат																						
1	МЧБО зөвлөх бэлтгэх-2	2012.01.09	ММСС		Д.Мөнхтогтох, Д.Ган-Оюун, Ш.Сосорбарам, А.Амарзаяа, О.Энхбаяр	10		ахисан шат	53		*	*	*		*	*		*	*	*	*	
2	АМЗ-үүдийг чадваржуулах сургалт	2014.10.06	ХТБ		АМУЗХ			ахисан шат			4	1	15	3		6	6					8.2
3	АМЧБ -2	2014.11.18	ГОУХАН		С.Л.Пержол	4	28	ахисан шат	14	2	8	8	6		2		*		*	*		2
4	АМЧБ -туршлага солилцох уулзалт	2016.06	ГОУХАН		Ш.Сосорбарам А.Амарзаяа	3		ахисан шат	8			*	*			*	*		*	*		
5	АМЧБО ахисан шат	2017.05	ГОУХАН	Өөрчлөлтийг чиглүүлэгч		4		ахисан шат	10				*						*	*		




6	Ажил мэргэжлийн кейс судлал	2017.09	ГОУХАН	ССҮТ		3		ахисан шат	13	*	*		*			*	*		*	*		
7	АМЧБО зөвлөх бэлтгэх	2017.11	ГОУХАН		Ш.Сосорбарам А.Амарзаяа	3		ахисан шат		*		*	*			*	*		*	*		
8	АМЧБО мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалт	2018.10.29	SECIM	МАММЗХ	Ш.Сосорбарам А.Амарзаяа	3		мэргэшсэн зөвлөх	35	*	*	*	*			*	*		*	*		
сургагч багш																						
1	МЧБ өгөх зөвлөхийн сургагч багш	2011.10.03	ММСС		Ц.Цэцэгмаа	25	160	сургагч багш	17		*	*	*		*	*	*		*	*	*	
2	АМЧБ -сургагч багш-1	2014.11.24	ГОУХАН		С.Л.Пержол	5	40	сургагч багш	14	2	10	8	3	2	4	4	2		*	*		2


2011-2018 оны хооронд зохион байгуулагдсан “Ажил мэргэжлийн олгох зөвлөх” бэлтгэх сургалтын талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэвэл:



Зөвлөх бэлтгэх анхан шатны нийт 18 сургалтын агуулгаар нь дүгнэж үзвэл 50%-д нь онолын үзэл баримтлал, сургалт зохион байгуулах арга зүй орсон бол, зөвлөгөө өгөх арга зүй, зөвлөхийн чадвар, ёс зүй агуулга 94,4% -д орсон байна. Ажил мэргэжлийн мэдээллийн менежмент 66,7% -д, оношилгоо хийх арга зүйн агуулга 55,6% нь орсон байна. Харин хамгийн бага орсон агуулга бол зорилтот бүлгийн онцлог 38,8 хувь, эрх зүйн орчин институтчлал 22 хувь, ажилд зуучлах талаарх агуулга тусгагдаагүй байна.



Дунд шатны 5 сургалт зохион байгуулагдсанаас зөвлөгөө өгөх арга зүй, зөвлөхийн чадвар, ёс зүй, ажил мэргэжлийн мэдээллийн менежментийн агуулгуудыг бүх сургалтад орсон байна. Сургалт зохион байгуулах арга зүй 80%, онолын үзэл баримтлал, эрх зүйн орчин институтчлал, оношилгоо хийх арга зүйн сургалтын 60%-д нь орсон байна. Зорилтот бүлгийн онцлог, ажилд зуучлах агуулга 20% буюу хамгийн бага орсон байна.



Зөвлөх бэлтгэх ахисан шатны 8 сургалтын агуулгад зөвлөхийн чадвар ёс зүй 100%, ажил мэргэжлийн мэдээллийн менежмент, сургалт зохион байгуулах арга зүй, оношилгоо хийх арга зүй тус бүр 75%, зөвлөгөө өгөх арга зүй 62.5%, онолын үзэл баримтлал 50%, эрх зүй орчин институтчилал 25%, зорилтот бүлгийн онцлог, ажилд зуучлах стратеги тус бүр 12.5% орсон байна.

Дүгнэлт

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох 3 шатны сургалтад зөвлөхийн ур чадвар, ёс зүй, зөвлөгөө өгөх арга техник гэсэн агуулгууд хамгийн их заагдсан байна. Энэ нь бид зөвлөхийн ёс зүй, зөвлөгөө өгөх чадвар дээр нэлээдгүй анхаарсныг харуулж байна. Харин зөвлөгөө өгөх суурь болох онолын мэдлэг, оношилгооны чадвар, бүлгийн сургалт зохион байгуулах арга зүйг цөөвөр сургалтад орсон нь энэ чадварууд хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүд, ажил мэргэжлийн зөвлөхүүдэд дутагдаж өөрсдийн амьдралын туршлагаар зөвлөх магадлалтайг илтгэж байна.

“Эрх зүйн орчин, институтчилал”-ын талаарх агуулга мөн цөөн сургалтад орж байгаа нь хууль, дүрэм, тушаал, журам, зөвлөмжийн хэрэглээнээс гадна үйлчлүүлэгчдэд өгөх мэдээллийн бүтцэд ихээхэн нөлөөлдөг тул энэ талын агуулгыг дараа дараагийн сургалтад заавал оруулах шаардлагатайг харуулж байна.

Мөн ажил мэргэжлийн зөвлөхийн үндсэн үйл ажиллагааны нэг болох “Ажилд зуучлах” үйлчилгээний талаарх агуулгыг маш бага орсон нь энэхүү үйл ажиллагааг тусад нь авч үзэх буюу зөвхөн ажилд зуучлах мэргэжилтэнд хамаатай ойлголт гэсэн нийтлэг алдаатай ойлголтыг харуулж байна. “Зорилтот бүлгийн онцлог”-ыг танин мэдэх, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгох, тэдэнтэй ажиллах арга зүйн талаарх агуулга ч мөн ялгаагүй бага байна. Харин сургалтын агуулгыг бататгах, оролцогчдыг идэвхжүүлэх, үйлдэн суралцуулах практик ажилбар хангалттай сайн хийгдсэн байна. Сургалтад мэдсэн сурсан зүйлээ бататгах, бие даан хэрэгжүүлэх буюу дадлага ажил бага тусгагдсан байна.

ХХҮЕГ-ын А/263 тоот тушаалаар хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтын жишиг агуулгыг баталсан. Гэвч зөвлөх бэлтгэх сургалтын хугацаа, давтамж, түвшин, залгамж холбоо, зохион байгуулалтыг тодорхойлж өгөөгүй. Мөн сургалт зохион байгуулах байгууллагын сонгон шалгаруулалт, чадавх г.м зэргийг тусгаагүй.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх нь нийгмийн хөгжлийг дэмжих, хөдөлмөрийн хуваарилалтыг боловсронгуй болгох, үйлчлүүлэгчийг хувь хүний болон эдийн засгийн хувьд үр нөлөөтэй байдлаар тохирох ажилд нь хуваарилах, мэргэжил эзэмшүүлэхэд чухал ач холбогдолтой хэмээн олон улсын судлаач эрдэмтэд санал нэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх сургалтад зайлшгүй тавигдах шаардлага байх ёстой. Ажил, мэргэжлийн зөвлөхийн ажлыг хийхийн тулд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагаар дамжуулан мэргэжлийн имижийг бүрдүүлсэн байх ёстой гэж зарим хүмүүс үздэг. Харин зарим хүмүүс үүний эсрэг байр суурийг баримталж дээрхтэй ижил төстэй, хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн загвар ашиглахгүй байхыг зөвлөдөг. Ингэснээр албан ёсны мэргэжил тусгайлан эзэмшээгүй ч ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох туршлагатай, идэвх санаачилгатай олон тооны зөвлөхүүд ажиллах боломжгүй болно гэж тэд үзсэн байна.

3.7 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам

✚ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний хүртээмж муу байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд үзүүлж буй ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын 13,2 хувь, МСҮТ, их дээд сургуулийн төгсөгчдийн 24,3 хувийг хамруулж байна.

Боловсролын салбарт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг сургуульд суурилсан хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү агуулга нь сургууль зохицуулах цагт хуваарилагдсан байна. Энэхүү зохицуулалтын хүрээнд тухайн сургууль аль ч хөтөлбөрийг сонгон авч боловсруулж хэрэгжүүлэх боломжтой тул ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө сургалтын үр дүн, хүртээмжийг таамаглах боломжгүй байна.

✚ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилтот бүлгийг хөдөлмөр эрхлэлтийн салбарт даган мөрдөж байгаа журмуудад нэгдсэн байдлаар тусгаагүй, өөр өөр байгаа нь тухайн үйлчилгээний хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

- I. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж /ХХҮЕГ А/179 2017.06.23/-д :
 1. Ажилгүй иргэд
 2. Ажил хайгч иргэн
 3. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн
 4. Ажил олоход хүндрэлтэй иргэн
 5. Их дээд сургууль, коллежийн оюутан
 6. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтад суралцагчид
 7. ЕБС-ийн ахлах ангийн сурагч
- II. Ажил мэргэжлийн баримжааг хөгжүүлэх чиглэл - Хөдөлмөрийн сайд, БСШУ сайдын А165/А266 хамтарсан тушаалд :
 - Хүүхэд, залуучууд (1.2.1);
 - 14. ЕБС-ийн ахлах ангийн суралцагч,
 - 15. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч

16. их, дээд сургууль, коллежийн оюутан;
 17. албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн;
 18. эцэг эх, асран хамгаалагчид;
 - Насанд хүрэгчид (1.2.2);
 19. Ажил хайгч иргэн
 20. Хугацаат цэргийн албан хаагч
 21. Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэн
 22. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад эх орондоо ирсэн иргэн
 23. Тэтгэврийн насны иргэн
 - Эмзэг болон эрсдэлтэй бүлгийн иргэн (1.2.3)
 24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
 25. Эмзэг эрсдэлтэй бүлгийн иргэн
 26. Хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэн
- III. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр агуулга/ХХҮЕГ А/249
2017.09.25
1. ЕБС-ийн ахлах ангийн сурагчид /VIII-XII/
 2. Мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагч
 3. Их, дээд сургууль, коллежийн оюутан
 4. Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдаж буй иргэн
 5. Ажил хайгч иргэн
 6. Хугацаат цэргийн алба хаагч
 7. Хөдөө орон нутгаас хот руу шилжин ирсэн иргэн
 8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
 9. Эмзэг, эрсдэлтэй бүлгийн иргэн
 10. Хорих ангид хүмүүжигч болон суллагдсан иргэн

Эдгээр журмуудад зорилтот бүлгийг 3 өөр байдлаар тусгасан нь хөдөлмөр эрхлэлтийн алба, нэгж, хөдөлмөрийн биржийн зөвлөхүүдэд үйл ажиллагаагаа зохион байгуулахад, мөн түүнчлэн хяналт мониторинг хийхэд ч тодорхойгүй байдал үүсгэж байна.

- ✚ **Боловсролын салбарт хэрэгжиж байгаа ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний зорилтот бүлэг, түүнд хүргэх агуулгыг тодорхой журамд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.**

Боловсролын ерөнхий хуульд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” агуулгыг бүх түвшний боловсрол, сургалтын хөтөлбөрт заавал тусгаж боловсрол сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

ЕБС-ийн ажил мэргэжлийн чиг баримжааны талаарх БСШУЯ-ны санаачилга²⁰

2015-17: БСШУСЯ нь ЕБС-ийн 8, 9 дүгээр ангид АМЧБ-ны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тэр дундаа 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн "Сонголтын 7 хоног"-ийн үйл ажиллагааг бүх сургуульд зохион байгуулсан байдаг. Энэ үйл ажиллагаатай холбоотой ЕБС-ийн удирдлага, 8, 9 дүгээр ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө боловсруулж төрийн өмчийн бүх сургуулиудад түгээсэн байна.

20 “Ажил мэргэжлийн чиг баримжаа” эцэг эх, асран хамгаалагчид зориулсан зөвлөмж, 2018, 6 хуудас

2018-19: БСШУСЯ нь ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдад чиглэсэн АМЧБ-ны үйл ажиллагааг хэрэгжүүлэх санаачилга гаргаж, холбогдох удирдамж, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан. Үүнтэй холбогдуулан ЕБС-ийн удирдлага, ахлах ангийн багш нар болон суралцагчдад зориулсан гарын авлага, төлөвлөгөө, хөтөч боловсруулж, төрийн өмчийн бүх сургуульд түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна. Энэ үйл ажиллагаа 2018- 2019 оны хичээлээс жилээс эхлэн бүх сургуульд хэрэгжүүлж эхэлсэн.

БСШУЯ-ны сайдын А200 тоот тушаалын дагуу ЕБС-ийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын чиглэлийг баталсан.

Харин МСҮТ, политехник коллеж болон их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудад зориулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний агуулга, тус ажлын зохион байгуулалт, хүргэх арга зам зэргийг тодорхойлж журамд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

✚ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний агуулга, хөтөлбөрийг зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн дахин шинэчлэх шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмж /ХХҮЕГ А/179 2017.06.23/-д Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө, сургалт – 80 минутаас ихгүй байх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө, сургалт – 30-40 минут байна гэж тусгасан.

Харин ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр агуулга /ХХҮЕГ А/249 тоот тушаалд зорилтот бүлгийн агуулга 8 ак.цагийн багтаамжтайгаар журамлагдсан.

БСШУ-ны сайдын А/200 тоот тушаалд 10-р ангид 12 цаг, 11-р ангид 12 цаг, 12-р ангид 10 цагаас доошгүй байхаар төлөвлөж оруулахаар тусгасан байна.

Эдгээр тушаалуудад сургалтын цагийг өөр хоорондоо харилцан адилгүй ялгаатай байдлаар тусгаж өгсөн нь тухайн агуулгыг хүргэх, зохион байгуулах зэрэгт нэлээдгүй хүндрэл учирч байна. Тиймээс зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн зөвлөгөө, сургалтын агуулга, хэлбэр, зохион байгуулалт зэргийг шинэчлэх шаардлагатай байна.

- ✚ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах эрэлт, хэрэгцээ үүсээд байна.
- ✚ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, сургалт явуулах орчны талаар тусгасан MNS6020-2016 стандартыг хангаж ажиллах шаардлагатай байна

4.1 Үндсэн чиглэл

МЭРГЭЖЛИЙН БАРИМЖАА ОЛГОХ АЖЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

/2024-2028/ (ТӨСӨЛ)

Нэг. Нийтлэг үндэслэл

Үндсэн чиглэл нь иргэдэд мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавхаа нээж хөгжүүлэх замаар ажил, мэргэжлээ үндэслэлтэй сонгож сурч эзэмших, үр бүтээлтэй ажиллаж, орлого олж сэтгэл хангалуун аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д: Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулга, сургагч багшид тавигдах шаардлагыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэх; Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлд: Албан боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгохоор; мөн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлд: түншлэгч аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүргийн хэсэгт иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилтны мэргэшлийн түвшнийг дээшлүүлэх, үр чадвар, чадамж эзэмшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулахаар тус тус заасан.

Хууль эрх зүйн болон бодлогын бусад баримт бичгийн холбогдох заалтуудыг үндэслэн ажил, мэргэжлийн баримжаа олгох ажлын чиглэл, зорилго, зорилтыг тодорхойлсон болно.

Хоёр. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын зорилго, зорилт

2.1. Зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчид, мэргэжлийн болон техникийн боловсролын суралцагчид, их дээд сургууль, коллежийн оюутнууд, ажил хайгч иргэдэд ажил мэргэжлийн баримжаа олгох, өөрийн сонирхол, чадавх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг харгалзан ажил мэргэжлээ үндэслэлтэй сонгох, үр дүнтэй сурч эзэмших, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааны агуулга, зохион байгуулалт, эрх зүйн нэгдмэл орчинг бүрдүүлэхэд оршино.

2.2. Зорилтууд

2.2.1. Ажил, мэргэжлийн баримжаа олгох систем (тогтолцоо)-ийг боловсронгуй болгох, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчныг сайжруулах

2.2.2. Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар анги, мэргэжлийн болон техникийн боловсрол, их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт “Ажил мэргэжлийн баримжаа” олгох хичээлийн агуулгыг тусгаж хэрэгжүүлэх

2.2.3. Боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажил мэргэжлийн баримжаа олгох багш, ажил мэргэжлийн зөвлөгч, хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтний мэргэшлийн түвшинд тавигдах шаардлагыг тодорхойлох, тэднийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг нь тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх

2.2.4. Ажил мэргэжлийн зөвлөгч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн стандарт, ажлын байрны тодорхойлолт, хариуцах ажил, үүргийн хуваарийг салбарын болон эрхлэх ажлын онцлогт нийцүүлэн шинэчлэн боловсруулах

2.2.5. Ажил мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр, сурах бичиг, арга зүйн гарын авлага боловсруулах, цахим эх сурвалжийг хөгжүүлэх

Гурав. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын агуулга

3.1. Ажил, мэргэжлийн талаар мэдээлэл өгөх

Нийгэм эдийн засаг, технологийн хөгжлийн хандлага, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон цаашдын төлөв, ажил мэргэжлүүд, тэдгээрийг сурч эзэмших арга зам, ажилтан хүний мэргэжлийн мэдлэг, чадамжид тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл өгөх

3.2. Ажил мэргэжлийн баримжаа олгох

3.2.1. Мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг харгалзан ажил, мэргэжлээ үндэслэлтэй сонгож сурч эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, иргэн бүрд тэгш боломжийг бүрдүүлэх

3.2.2. Ерөнхий боловсролын сурагчид, мэргэжлийн боловсролын суралцагчид, их, дээд сургуулийн оюутнууд болон насанд хүрэгчдэд ажил мэргэжлийн баримжаа олгох сургалт явуулах, мэргэжлийн үйл ажиллагаатай танилцуулах, зөвлөгөө өгөх

3.2.3. Боловсролын болон сургалтын байгууллагууд сурагчид, суралцагчид, оюутнууд, насанд хүрэгчдэд ажил мэргэжлийн хөгжлөө төлөвлөх, удирдаж хэрэгжүүлэх, амжилтад хүрэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох

3.3. Ажил, мэргэжилдээ зохицоход нь туслах

Сонгосон мэргэжлээ үр дүнтэй сурч эзэмших, мэргэжлийн ажилдаа зохицох, сорилт бэрхшээлийг давах, өндөр бүтээмжтэй ажиллах, мэргэжлийнхээ хүрээнд тасралтгүй хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх

3.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

3.4.1. Ажил хайгч иргэд, шилжин суурьшигчид, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай иргэд болон бусад зорилтот бүлгийн иргэдийн ажил мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавх, боломжийг харгалзан мэргэжлийн сургалтад хамруулах, дадлагажуулах, кейс менежмент хийх, ажлын байранд зуучлах

3.4.2. Их дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын төгсөгчид, насанд хүрэгчид, зорилтот бүлгийн иргэдийг ажил хайх, ажлын байранд өргөдөл гаргах, ажлын ярилцлагад орох, өөрийн маркетингийн аргад сургаж бэлтгэх, ажлын байранд зуучлах

Дөрөв. Ажил мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагаанд хамрагдах зорилтот бүлэг

4.1. Суралцагчид, эцэг эх

- 4.1.1. Ерөнхий боловсролын 8-12 ангийн сурагчид;
- 4.1.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын суралцагчид;
- 4.1.3. Дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын оюутнууд;
- 4.1.4. Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдан суралцаж буй иргэд;
- 4.1.5. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч

4.2. Насанд хүрэгчид

- 4.2.1. Ажил хайгч иргэд;

- 4.2.2. Хугацаат цэргийн албан хаагчид;
- 4.2.3. Шилжин суурьшигч иргэд;
- 4.2.4. Тэтгэврийн өмнөх болон тэтгэврийн насны иргэд;

4.3. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, ажил олоход хүндрэлтэй иргэд

- 4.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
- 4.3.2. Нийгмийн халамж туслалцаа шаардлагатай иргэд;
- 4.3.3. Хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэд;

Тав. Ажил мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцогч талууд

- 5.1. Өрх гэр
- 5.2. Ерөнхий боловсролын сургууль
- 5.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагууд, дээд боловсролын сургалтын байгууллагууд
- 5.4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж
- 5.5. Ажил олгогчид (Үйлдвэр, компани, байгууллагууд)
- 5.6. Хууль сахиулах байгууллага
- 5.7. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- 5.8. Цэргийн байгууллага
- 5.9. Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага
- 5.10. Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх төвүүд
- 5.11. Төрийн байгууллага

Зургаа. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын удирдлага, зохион байгуулалт

- 6.1. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын удирдлага, зохицуулалтыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан, зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- 6.2. Төрийн захиргааны төв байгууллагад ажил мэргэжлийн баримжаа олгох ажлыг хариуцсан нэгж, эсвэл албан тушаалтан ажиллана.

Долоо. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 7.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах зорилтот бүлэгт мэргэжлийн баримжаа олгох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлнэ:
 - Ерөнхий боловсролын 8-12 ангийн сурагчид;
 - Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид;
 - Коллеж, дээд сургууль, их сургуулийн оюутнууд;
 - Албан бус боловсролын хөтөлбөрт хамрагдан суралцаж буй иргэд;
 - Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид;
- 7.2. Боловсролын бүх түвшний (ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын) суралцагчдад мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ

- 7.3. Ерөнхий боловсролын сургуульд судлах ажил, мэргэжлийн баримжаа олгох хичээлийн хөтөлбөр, сурах бичиг, арга зүйн гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр бэлтгэх
- 7.4. Ажил, мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэгч салбарын байгууллагууд (ЕБС, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургууль, аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар)-ын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх, хяналт шинжилгээ хийх
- 7.5. Ерөнхий боловсролын судлагдахуун хичээлийн багш нарыг хичээлээ мэргэжил, мэргэжлийн үйл ажиллагаатай холбож заах арга зүйд сургах
- 7.6. Ерөнхий боловсролын 8–12 дугаар ангийн анги удирдсан багш, боловсролын сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудыг “Ажил мэргэжлийн баримжаа олгох арга зүй” чиглэлээр сургаж бэлтгэх
- 7.7. Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг хөтөлбөр, боловсролын сэтгэл судлаач бэлтгэдэг хөтөлбөр, мөн багш нарын мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт “ажил, мэргэжлийн баримжаа олгох арга зүй” хичээлийг тусгаж хэрэгжүүлэх

Найм. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 8.1. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах зорилтот бүлгийн иргэдэд ажил, мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана:
- Ажил хайгч иргэд;
 - Хугацаат цэргийн албан хаагчид;
 - Шилжин суурьшигч иргэд;
 - Тэтгэврийн өмнөх болон тэтгэврийн насны иргэд;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
 - Нийгмийн халамж туслалцаа шаардлагатай иргэд;
 - Хорих ангид хүмүүжигчид болон суллагдсан иргэд.
- 8.2. Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлыг зохицуулах, гүйцэтгэлд хяналт тавих журмыг боловсруулан мөрдөж ажиллах
- 8.3. Зорилтот бүлгийн иргэдэд ажил, мэргэжлийн баримжаа олгох нэгдсэн арга зүй боловсруулж хэрэгжүүлэх
- 8.4. Сургалтын хөтөлбөр, гарын авлага, бусад хэрэглэгдэхүүнийг нэгдсэн арга зүйд нийцүүлэн боловсруулах
- 8.5. Ажил мэргэжлийн баримжаа олгох мэргэжилтнүүд, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын мэргэжилтнүүд, хөдөлмөрийн биржийн ажилтнуудыг ажил мэргэжлийн баримжаа олгох арга зүйд сургаж бэлтгэх
- 8.6. Ажил, мэргэжлийн баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагууд (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн бирж, сургалтын байгууллага, төрийн бус байгууллага)-ын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх, хяналт шинжилгээг тогтмол хийж ажиллах

Ес. Хүрэх үр дүн

- 9.1. Боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд ажил мэргэжлийн баримжаа олгох систем (тогтолцоо)-ийг бэхжүүлснээр ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний хүртээмж, үр нөлөө дээшилнэ.
- 9.2. Ерөнхий боловсролын 8–12 дугаар ангийн сургалтын хөтөлбөрт ажил, мэргэжлийн баримжаа олгох хичээлийг тусгаж хэрэгжүүлснээр сурагчид мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавхаа танин мэдэж, мэргэжлийн ирээдүйгээ зөв баримжаалж, зорилготой сурч хөгжих, үр бүтээлтэй ажиллах боломж нэмэгдэнэ.
- 9.3. Их дээд сургууль, коллежийн оюутнууд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн суралцагчид мэргэжлийн чадамжийг амжилттай эзэмших, өндөр бүтээмжтэй ажиллах, карьерын хөгжлөө удирдах, тасралтгүй хөгжихөд суралцана.
- 9.3. Ажил, мэргэжлийн баримжаа олгох үйл ажиллагааны чанар дээшилж, иргэдийг ажлын байрны шаардлагад нийцүүлэн үр дүнтэй сургаж чадваржуулна. Улмаар ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
- 9.4. Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээг хэрэгжүүлэх мэргэжлийн чадавх бүрэлдэнэ (мэргэжлийн баримжаа олгох багш, ажил мэргэжлийн зөвлөгч, хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийн чадавх бэхжин).
- 9.5. Ажил мэргэжлийн баримжаа зүйн мэдлэгийн сан бүрдэнэ (сургалтын хөтөлбөр, ажил мэргэжил судлалын онол, аргазүйн ном, гарын авлага, лавлах толь бичиг, мэргэжлийн стандарт, ажлын байрны тодорхойлолтын г.м)

4.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх чадавхжуулах сургалтын хөтөлбөр

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН БАРИМЖАА ОЛГОХ ЗӨВЛӨХ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ЗӨВЛӨХИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ, СУУРЬ ЧАДАМЖ

Ажил мэргэжлийн баримжаа олгох зөвлөх үйлчилгээ нь аль ч насны хүмүүст амьдралынх нь ямар ч үед боловсрол эзэмших, сурах, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой сонголт хийх, карьерын менежмент хийхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагаа юм.

ҮНДСЭН ЧАДАМЖ (Зөвлөхийн ур чадвар, үнэт зүйл)	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙ ХАРИЛЦАХАД ШААРДАГДАХ ЧАДАМЖ (Ажил хайгч, ажил олгогчидтой хамтран ажиллах)	ТУСЛАХ ЧАДАМЖ (Систем, нийгмийн сүлжээ)
- Мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулах - Үйлчлүүлэгчид чиглэсэн хандлага - Сорилт/өөрчлөлттэй зохистой харьцах	- Зөвлөгөө өгөх болон хувь хүний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах - Нэгтгэх, идэвхжүүлэх үйл явцын удирдлага, хяналт - Ажил хайгчдад ажлын байр олоход нь дэмжлэг үзүүлэх - Ажил олгогчдод ажилтан сонгон шалгаруулахад дэмжлэг үзүүлэх	- Үйлчлүүлэгчид болон бусад оролцогч талуудтай харилцахдаа хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлөх чадвартай байх - Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, боловсрол, мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдлэгтэй байх - Зорилтот бүлгийн талаар мэдлэгтэй байх

Модуль	Агуулга
Суурь ур чадвар олгох сургалт (цахим)	
Модуль 1 Ажил мэргэжлийн баримжаа олгох үндсэн үзэл баримтлал, зөвлөх үйлчилгээний суурь	- Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин - Ажил мэргэжлийн баримжаа олгох үйлчилгээний институтчилал - Ажил мэргэжлийн зөвлөхийн чадамж
Модуль 2 Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөхөд ашиглагддаг онол, үзэл баримтлал	- Бие хүний мэргэжлийн хөгжлийн үйл явц, үе шат - Мэргэжил сонголтын онол, үзэл баримтлал - Бие хүний сэтгэл зүйн шинж чанарууд
Модуль 3 Ажил мэргэжлийн зөвлөхийн мэдээллийн менежмент * I	Ажил мэргэжлийн мэдээллийн сан
Ахисан түвшний сургалт (танхим)	
Модуль 1 Ажил мэргэжлийн зөвлөхийн ёс зүй, зөвлөхийн суурь чадамж	- Зөвлөхийн ёс зүй - Зөвлөхийн суурь чадамж
Модуль 2 Бие хүний үйлдэл ба шийдвэр гаргалт	- Шийдвэр гаргах үйл явц - Хязгаарлагдмал рациональ шийдвэр гаргалт
Модуль 3 Зөвлөгөө өгөх чадамж, арга техник	- Зөвлөгөө өгөх үндсэн арга техник - Танин мэдэхүйн үл нийцэл - Эганы зөвлөгөө өгөх загвар “Шийдэл төвт” зөвлөгөө
Модуль 4 Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх зорилгоор оношилгоо хийх арга зүй	- Бие хүний мэргэжлийн хэв шинжийг тодорхойлох нь - Бие хүний сэтгэл зүйн шинж чанарыг оношлох нь

Модуль 5	Ажил мэргэжлийн зөвлөхийн мэдээллийн менежмент* II		- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо ба оролцогч талууд - Боловсролын тогтолцоо ба оролцогч талууд
Дадлагын ажил			
Модуль 6	Зорилтот бүлгийн иргэдийн нийгэм, сэтгэл зүйн онцлог		- Нийгмийн бүлгийн төрөл, хэлбэр - Зорилтот бүлгийн нийгэм, сэтгэл зүйн онцлог
Модуль 7	Бүлгийн зөвлөгөө, сургалт зохион байгуулах арга зүй		- Бүлгийн зөвлөгөөний үндсэн ойлголт, арга зүй - Сургалт зохион байгуулах арга, техник
Модуль 8	Ажилд зуучлах стратеги		- Ажилд зуучлах тогтолцоо, үйлчилгээний үндсэн үүрэг - Ажилд зуучлах стратеги
Мэргэшүүлэх сургалт (танхим) – жил бүр 2кр			

4.3 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны жишиг хөтөлбөр (Боловсролын салбар)

Мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжил сонголтоо үндэслэлтэй хийхэд туслах, карьерын төлөвлөлтөө хийхэд нь дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх,

Их, дээд сургууль, МСҮТ политехник коллежийн оюутан, суралцагчдад карьерын төлөвлөлтөө хийх, удирдахад нь дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээл рүү амжилттай шилжихэд нь чадавхжуулах

Мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын зорилт

- Оюутан, суралцагч бүр хувь хүний онцлогоо танин мэдэх, хөгжүүлэх
- Ажил, мэргэжлийн талаар ойлголттой болох
- Хувийн болон карьерын зорилгодоо хүрэхэд шаардлагатай боловсролын түвшин тодорхойлох, гүйцэтгэлийн түвшин хангах
- Оюутан, суралцагч бүр өөрийн карьерын зорилгод нийцсэн төлөвлөгөөг гаргаж удирдахад дэмжлэг үзүүлэх

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хэлбэр

- Бүлгийн сургалт
- Ганцаарчилсан зөвлөгөө
- Мэргэжилтэй танилцах үйл ажиллагаа

Хамрах хүрээ

- ЕБС-ийн ахлах ангийн сурагчид
- Их, дээд сургуулийн оюутан
- МСҮТ, политехник коллежийн суралцагчид

Зохион байгуулагч

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагууд

Оролцогч талууд

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагууд, аж ахуй нэгж байгууллагууд, эцэг эх, асран хамгаалагч, мэргэжлийн байгууллагууд

Зохион байгуулалт

Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, политехник коллеж, их, дээд сургууль ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг бүлгийн сургалт болон ганцаарчилсан зөвлөгөө хэлбэрээр хүргэнэ. Мэргэжилтэй танилцах үйл ажиллагааг харьяа аймаг/дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтэстэй гэрээ байгуулж, хамтран зохион байгуулна.

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

- Сургалт, зөвлөгөө, үйл ажиллагаанд оролцсон оюутан, суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр зохион байгуулагдсан үйл ажиллагааны тоо
- Бүлгийн сургалтад хамрагдсан оюутан, суралцагчдын тоо
- Ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдсан оюутан, суралцагчдын тоо
- Мэргэжилтэй танилцах үйл ажиллагаанд хамрагдсан оюутан, суралцагчдын тоо

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны жишиг хөтөлбөр

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад		Анги				
		8	9	10	11	12
БҮЛГИЙН СУРГАЛТ						
Танин мэдэх үе шат						
Мэргэжил сонголтын тухай ерөнхий ойлголт		✓		✓		
Хөдөлмөр эрхлэх чадварын тухай ойлголт			✓			✓
Мэргэжил гэж юу вэ? (сонирхон судалж буй мэргэжлийн тухай мэдвэл зохих 10 зүйл)		✓	✓	✓	✓	
Ажил мэргэжлийн талаар эрэл хайгуул хийх		✓	✓	✓	✓	
Хөдөлмөрийн зах зээлийн тухай ойлголт			✓	✓	✓	✓
Шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх загвар			✓			✓
Мэргэжил боловсрол эзэмших арга замууд			✓	✓	✓	✓
Мэргэжилд чиглэсэн хүсэл сонирхлоо тодорхойлох аргачлал		✓	✓	✓	✓	✓
Мэргэжилтэй танилцах төлөвлөгөө		✓	✓	✓	✓	
Карьерын хөгжлийн төлөвлөгөө хийх аргачлал			✓			✓
Дадал зуршил		✓	✓	✓	✓	✓
Суралцах арга барилаа хөгжүүлэх нь		✓	✓	✓		✓
Цагийн менежмент		✓	✓	✓	✓	✓
Харилцаа, хүмүүс хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх нь			✓	✓	✓	✓
Өөрийн үнэлгээ (нөхцөл байдлаа тодорхойлох) аргачлал		✓	✓	✓	✓	✓
Өөрийн үнэлгээ (Ахиц дэвшлийн үнэлгээ)-ний ач холбогдол		✓	✓		✓	
Сургууль судлах аргачлал			✓		✓	✓
Сайн дурын ажил			✓		✓	✓
Цагийн ажил			✓		✓	✓
Мэргэжилд чухал шинж чанар гэж юу вэ?			✓	✓	✓	✓
Их дээд сургууль, коллежийн элсэлтийн процесс			✓		✓	✓
Сэдэл төрж, итгэл үнэмшил бий болох үе шат						
Өөрийгөө танин мэдэх алхмууд	Харилцааны шинж чанар		✓	✓		
	Зан төлөвөө тодорхойлох		✓	✓		
	Үнэт зүйл		✓	✓		
	Миний мөрөөдөл		✓	✓	✓	
	Миний ирээдүйн зорилго	✓	✓	✓	✓	✓
	Миний ойрын зорилтууд	✓	✓	✓	✓	✓
	Мэргэжилд чиглэсэн хүсэл сонирхлоо танин мэдэх		✓	✓	✓	
	Дадал зуршил	✓	✓	✓	✓	✓
	Суралцах арга барилаа тодорхойлох	✓	✓	✓	✓	✓
	Цагийн менежмент		✓	✓	✓	✓
Өөрийн үнэлгээ (нөхцөл байдлаа тодорхойлох)		✓	✓		✓	✓
Ажил мэргэжлийн эрэл хайгуул хийх төлөвлөгөө		✓	✓	✓	✓	✓

Сургууль судлах төлөвлөгөө		✓		✓	✓
Өөрийн үнэлгээ (Ахиц дэвшлийн үнэлгээ)	✓	✓	✓	✓	✓
Карьерын төлөвлөгөө боловсруулах		✓			✓
Ажил мэргэжлийн мэдээллээ бусдад хуваалцах цаг	✓	✓	✓	✓	✓
Ангидаа ажил мэргэжлийн мэдээллийн сантай болох	✓	✓	✓	✓	✓
МЭРГЭЖИЛТЭЙ ТАНИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА					
Үйлдэх үе шат					
Төрөл бүрийн мэргэжилтэнтэй хийх уулзалт зохион байгуулах:	Мэргэжилтэнтэй уулзах (төрөл бүрийн мэргэжлээр)		✓	✓	✓
	Төгсөгчидтэй уулзалт зохион байгуулах		✓	✓	✓
Мэргэжилтэй танилцах аялал: Орон нутгийн үйлдвэр, аж ахуй нэгж, коллежуудаар аялал зохион байгуулж ажлын орчинг бодитоор танилцуулах		✓	✓	✓	✓
Мэргэжил турших ажилбаруудыг хийх боломж бүрдүүлэх		✓	✓	✓	✓
Сайн дурын ажлуудад оролцох боломж бүрдүүлэх			✓		✓
Цагийн ажил хийх боломж бүрдүүлэх			✓		✓

Их, дээд сургууль, МСҮТ, политехник коллежийн оюутан сурагчдад		Курс			
		1	2	3	4
БҮЛГИЙН СУРГАЛТ					
Танин мэдэх үе шат					
Сонгон суралцаж буй хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулга		✓			
Мэргэжилд чухал шинж чанарын тухай ойлголттой болох			✓		✓
Карьерын хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлал			✓		✓
Ажил олгогчийн тухай (Үйлдвэрийн дадлагаар хамтран ажилдаг ажил олгогчийг танилцуулах, ажил олгогчийн төрөл, байгууллагын соёл, шинэ ажилтан, хөдөлмөрийн гэрээ, абт, байгууллагын дотоод журмыг товч оруулах)			✓	✓	✓
Ажил олгогчийг судлах (Мөрөөдлийн ажлаа зураглах, ажил хайх сүлжээний тухай ойлголттой болох)			✓		✓
Ажилд орох процесс хэрхэн явагддаг вэ?			✓		✓
Ажилд ороход шаардагдах бичиг баримтууд (Сонгон шалгаруулалт, портфолио тухай)			✓		✓
Ажлын ярилцлагын үеэр ирдэг түгээмэл асуултууд			✓		✓
Хөдөлмөрийн гэрээ, АБТ, Байгууллагын дотоод журам			✓		✓
Сэдэл төрж, итгэл үнэмшил бий болох үе шат					
Миний эзэмших бодит ур чадвар ажилбар			✓	✓	
Суралцах зорилгоо тодорхойлох , амжилттай суралцах төлөвлөгөө боловсруулах (өөртөө захидал бичих дасгал ажилтай)		✓			
Эцэг эх, асран хамгаалагчидтай хийх уулзалт (Сургуулийн үйл ажиллагаа, бүтээлийн үзэсгэлэн, эцэг эхийн үүрэг, хичээлийн хуваарь, шалгалтын хуваарь, хичээлээс гадуур зохион байгуулагдах үйл ажиллагаа, нийтлэг гардаг зөрчил гм)		✓	✓		✓
Хувийн ур чадварууд хөгжүүлэх ажилбарууд	Зорилгоо тодорхойлох	✓	✓	✓	✓
	Алсын хараа, зарчмаа тодорхойлох	✓	✓	✓	✓
	Дадал зуршлын хүч	✓	✓	✓	✓
	Цагийн менежмент	✓	✓	✓	✓
	Ес зүй ба мораль	✓	✓	✓	✓

	Шийдвэр гаргах чадвар		✓	✓	✓
	Баг гэж юу вэ? багт гүйцэтгэх үүрэг		✓	✓	✓
	Харилцааны ур чадвар	✓	✓	✓	✓
Карьерын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах			✓		✓
Мөрөөдлийн ажлаа зураглах, ажил хайх сүлжээгээ зураглах			✓		✓
CV			✓		✓
Намтар			✓	✓	✓
Анкет			✓		✓
Ажилд орох өргөдөл			✓		✓
Ажлын ярилцлагад бэлтгэх			✓		✓
ҮЙЛ АЖИЛЛАГАА					
Үйлдэх үе шат					
Мэргэжилтэнтэй хийх уулзалт:	Амжилтаа хуваалцъя уулзалт (Төгсөгчидтэй хийх ярилцлага)	✓	✓	✓	✓
	Төрөл бүрийн салбарт ажиллаж буй мэргэжилтэнтэй хийх уулзалт	✓	✓	✓	✓
Үйлдвэр аж ахуй нэгжтэй танилцах аялал		✓	✓		✓
Job Fair (Байгууллагын хүний нөөцтэй ярилцах орчин бүрдүүлэх)			✓	✓	✓
Ажлын ярилцлагыг бодитоор турших (Хүний нөөцийн ажилтнуудтай)			✓		✓
Сайн дурын ажлуудад оролцох боломж бүрдүүлэх			✓	✓	✓
Цагийн ажил хийх боломж бүрдүүлэх			✓	✓	✓